



# ХҮН ХУДАЛДААЛАХ, ТҮҮНТЭЙ ТӨСТЭЙ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

- •
- •
- •
- •
- •
- •
- •
- •





World Vision

The Asia Foundation



**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТҮНШЛЭЛИЙН КОМПАКТ:**

# **ХҮН ХУДАЛДААЛАХ, ТҮҮНТЭЙ ТӨСТЭЙ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Улаанбаатар хот  
2022 он

Энэхүү судалгааны тайланг Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн болно. Энд дурдагдсан үзэл бодол, үр дүн, мэдээлэл, дүгнэлт нь зөвхөн зохиогчийнх бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын болон Азийн сангийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

Хэрвээ та бүхэнд судалгааны тайланд санал хүсэлт байвал доорх хаягаар бидэнтэй холбогдоорой.

Монгол Улс, Улаанбаатар хот 211238

Шуудангийн хайрцаг-321, Утас/факс: 976-11-311512

Итгэлийн утас: 1800-1903

Нүүр хуудас: Mongolia Gender Equality Center

И-мэйл: [gendereqcen@magicnet.mn](mailto:gendereqcen@magicnet.mn)

Вэб хуудас: [www.stoptrafficking.mn](http://www.stoptrafficking.mn)

## АГУУЛГА

Өмнөх үг .....	4
Талархал.....	5
Товчилсон үг .....	6
Зургийн жагсаалт .....	7
Хүснэгтийн жагсаалт.....	8
Шигтгээ.....	9
Судалгааны хураангуй .....	10
Судалгааны зорилго, зорилт .....	13
Судалгааны арга зүй, аргачлал.....	15
Мэдээлэл цуглуулах явцад гарсан хүндрэл бэрхшээл, даван туулсан байдал, сургамж .....	20

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ХҮН ХУДАЛДААЛАХ БОЛОН ТҮҮНТЭЙ ТӨСТЭЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ .....**

22

1.1. Олон улсын эрх зүйн зохицуулалт.....	22
1.2. Үндэсний эрх зүйн зохицуулалт.....	28

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХҮН ХУДАЛДААЛАХ БОЛОН ТҮҮНТЭЙ ТӨСТЭЙ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА.....**

32

2.1. Зөрчил шалгаж, шийдвэрлэх ажиллагаа .....	32
2.2. Мөрдөн шалгах ажиллагаа .....	38
2.3. Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа .....	68

Дүгнэлт .....	81
Зөвлөмж.....	86
Ашигласан материал.....	94

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Засгийн газар нь АНУ-ын Төрийн Департаменттай хамтран таван жилийн (2020-2024 он) хугацаатай “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээ”-г байгуулсан. Тус Гэрээний гол зорилго нь Монгол Улсад хүүхэд худалдаалсан гэмт этгээдийг хуулийн дагуу яллаж, зохих ял шийтгэлийг оногдуулах чиглэлээрх Монгол Улсын төрийн холбогдох байгууллагууд, төрийн бус байгууллагын болон иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлж, эдгээр гэмт хэргийн хохирогч хүүхдүүдэд зориулсан учирсан гэмтэл, хохирлыг нөхөн сэргээхэд чиглэсэн цогц үйлчилгээ үзүүлж, улмаар Монгол Улс даяар хүүхэд худалдаалах гэмт хэргийн бүх төрлөөс урьдчилсан сэргийлэхэд чиглэхээр тохиролцсон. МУ-ын Засгийн газрыг төлөөлөн Хууль зүйн, дотоод хэргийн яам (ХЗДХЯ), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Улсын Ерөнхий Прокурорын газар (УЕПГ), Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл (ГХУСАЗЗ) ажиллаж байгаа бөгөөд төслийг хэрэгжүүлэгч нь Дэлхийн зөн Монгол ОУБ, Азийн сан юм.

Хүйсийн тэгш эрх төв нь Азийн сантай “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээ” ний хүрээнд 2021 оны 04 дүгээр сараас эхэлсэн хамтын ажиллагааны нэг хэсэг болох хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийж улмаар өнөөгийн нөхцөл байдлыг тодруулахыг зорьсон судалгааны тайланг боловсруулан хэвлүүлж олон нийтийн хүртээл болгож байгаад таатай байна.

Судалгааны тайланд хүн худалдаалах хэрэг түүний төрөл, хэлбэрүүдийг илрүүлэх, хянах, шийдвэрлэх үйл явцын талаар тоо мэдээ, хавтаст хэргийн материал болон хохирогчдын санал дүгнэлтэд тулгуурлаж, олон улсын болон дотоодын хууль, гэрээ конвенцуудтай харьцуулсан дүн шинжилгээ хийсэн. Тиймээс цаашид хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд гарч буй хүндрэл, бэрхшээлийг хэрхэн сайжруулах санал зөвлөмжийг нотолгоонд суурилсан бодлогын баримт бичиг боловсруулахад эх сурвалж болно гэдэгт итгэлтэй байна.

Тус дүн шинжилгээг хийсэн судалгааны баг болон техникийн зөвлөгөө өгч ажилласан Азийн сангийн Төслийн багийн хамт олонд баярласнаа илэрхийлье.

Г.Ганбаясгах

Тэргүүн

Хүйсийн тэгш эрх төв ТББ

## ТАЛАРХАЛ

Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээний хүрээнд хийгдэж буй Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийх дүн шинжилгээ судалгааны тайлан нь Монгол Улс дахь хүн худалдаалах болон түүнтэй төстэй хэргийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч бүртгэхээс эхлэн шүүхээр эцэслэн шийдвэрлэх хүртэлх хугацаанд явагдаж буй процессын өнөөгийн байдал, цаашид сайжруулах шаардлагатай үйл ажиллагааны талаар зөвлөмж хүргүүлнэ.

Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ төрийн эрх бүхий байгууллагын статистик мэдээллээс гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудтай ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулж, үр дүнг нэгтгэн авч үзлээ.

Судалгааны багийн зүгээс энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхэд туслалцаа үзүүлсэн Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ)-ны дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба (ГХУСАЗЗАА), Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ), Улсын ерөнхий прокурорын газар (УЕПГ), Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ) болон судалгаанд хамрагдсан өмгөөлөгч, бусад байгууллагын оролцогч, үзэл бодол туршлагаа хуваалцсан нийт хүмүүст талархаж байна.

Ялангуяа судалгааны явцад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан Хүйсийн тэгш эрх төв (ХТЭТ) болон Азийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын хамт олонд талархал илэрхийлье.

### МЭДЭГДЭЛ

Энэхүү судалгааны тайлангийн дүгнэлт, зөвлөмж нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ХТЭТ болон Азийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, судалгаанд хамрагдсан бусад оролцогч талуудын байр суурийг илэрхийлэхгүй болно.

### СУДАЛГААНЫ БАГ

Г.Амаржаргал	Судалгааны багийн ахлагч, Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн сургалтын арга зүйч
Д.Очмандах	Судалгааны багийн гишүүн, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүгч
С.Оюунжаргал	Судалгааны багийн гишүүн, Баянзүрх дүүргийн прокурорын газрын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналт хариуцсан ахлах прокурор
Ц.Шийтэрчулуун	Судалгааны багийн гишүүн, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч

## ТОВЧИЛСОН ҮГ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ББШ	Баримт бичгийн шинжилгээ
БСШУСЯ	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГБХЗХХ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГХЯ	Гадаад хэргийн яам
ДЗМОУБ	Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллага
ЗШШТХ	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
УИХ	Улсын Их Хурал
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
Палермогийн протокол	Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол
ТББ	Төрийн бус байгууллага
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХТЭТ	Хүйсийн тэгш эрх төв
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШШҮХ	Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭЦА	Эрүүгийн цагдаагийн алба

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Судалгааны арга зүй	15
Зураг 2.	Хохирогчдын насны байдал	17
Зураг 3.	Хохирогчдын амьдарч буй байршил	17
Зураг 4.	Хохирогчдын боловсрол	18
Зураг 5.	Хохирогчдын гэр бүлийн байдал	18
Зураг 6.	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн Зөрчлийн тухай хуулийн 6.18.4, 6.18.7 дахь хэсэгт заасан зөрчлийн статистик мэдээлэл	33
Зураг 7.	Зөрчлийн тухай хуулиар шийтгэл хүлээсэн эмэгтэй холбогдогч нарын насны бүтэц	35
Зураг 8.	Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, шийдвэрлэх ажиллагааны процессын зураглал	38
Зураг 9.	Хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах, шийдвэрлэх үеийн процессын зураглал	39
Зураг 10.	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	42
Зураг 11.	2020, 2021 онд бүртгэгдсэн зарим гэмт хэрэг хохирогчоор тогтоогдсон насанд хүрээгүй хүний тоон харьцуулалт	43
Зураг 12.	Хуулийн байгууллагад хандсан хохирогчдод учирдаг айдас, дарамт	55
Зураг 13.	Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх хугацааны зураглал	59
Зураг 14.	Хохирогчдод учирч байсан дарамт, заналхийлэл	66
Зураг 15.	Хүн худалдаалах гэмт хэргийн хөдөлгөөн	69
Зураг 16.	Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хөдөлгөөн	69
Зураг 17.	Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн хөдөлгөөн	70
Зураг 18.	Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн хөдөлгөөн	71
Зураг 19.	Хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах гэмт хэргийн хөдөлгөөн	71
Зураг 20.	Хүүхдээр гуйлга гуйлгах гэмт хэргийн хөдөлгөөн	71
Зураг 21.	Хүүхэд худалдах гэмт хэргийн хөдөлгөөн	72
Зураг 22.	Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэргийн хөдөлгөөн	72
Зураг 23.	Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах гэмт хэргийн хөдөлгөөн	72
Зураг 24.	Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийн хөдөлгөөн	73
Зураг 25.	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн шийдвэрлэлтийн инфо-график	73
Зураг 26.	2021 онд хүн худалдаалах болон түүнтэй төстэй хэргийг хэрэгсэхгүй болгосон, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан харьцуулалт	74
Зураг 27.	ХХГХ болон түүнтэй төстэй хэргийг дагнан шийдвэрлэх шүүгчийн албан тушаал шаардлагагүй гэж үзсэн шүүгчдийн гаргасан үндэслэл	76
Зураг 28.	Хохирогчдоос гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэх боломжгүй шалтгаан	78



## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Судалгааны зорилго, зорилтууд	13
Хүснэгт 2.	Чанарын ярилцлагад оролцсон оролцогчдын тоо	16
Хүснэгт 3.	Судалгаанд оролцогчдын хүйсийн мэдээлэл	17
Хүснэгт 4.	Палермогийн протокол болон Монгол Улсын Эрүүгийн хуулийн харьцуулалт	23
Хүснэгт 5.	Монгол Улсын нэгдэн орсон хүн худалдаалахтай тэмцэх чиглэлийн Олон улсын гэрээ, конвенцын жагсаалт	24
Хүснэгт 6.	Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэхээр гэрээ байгуулсан улс орны жагсаалт	26
Хүснэгт 7.	Зөрчлийн хэрэг болон холбогдогчийн тоо	34
Хүснэгт 8.	Зөрчилд холбогдсон хүмүүсийн өмнө нь шийтгэгдэж байсан тоо, шийтгэгдсэн зүйл хэсэг	35
Хүснэгт 9.	Хүн худалдаалах болон Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн харьцуулалт	47
Хүснэгт 10.	Хүн худалдаалах болон албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн харьцуулалт	48
Хүснэгт 11.	Хүн худалдаалах болон Хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах гэмт хэргийн харьцуулалт	49
Хүснэгт 12.	Хүн худалдаалах болон хүүхдийн эсрэг үйлдэж буй энэ төрлийн гэмт хэргийн харьцуулалт	50
Хүснэгт 13.	Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зарим гэмт хэрэгт оногдуулахаар заасан эрүүгийн хариуцлагын харьцуулалт	52
Хүснэгт 14.	ЭХХШТХ-д заасан зарим зохицуулалт	55
Хүснэгт 15.	Хохирогчдоос авсан судалгааны үр дүн /хугацаа/	57
Хүснэгт 16.	Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэргийн талаарх нэгтгэсэн мэдээлэл	58
Хүснэгт 17.	Судалгаанд оролцсон 20 хохирогчийн хүн худалдаалах гэмт хэрэгт хохирсон байршил	61
Хүснэгт 18.	Нэхэмжлэл гаргаагүй шалтгаан	67

## ШИГТГЭЭ

Шигтгээ 1.	Цагдаагийн алба хаагчтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	33
Шигтгээ 2.	Зөрчлийн хэргийн материалаас	34
Шигтгээ 3.	Зөрчлийн хэргийн материалаас	37
Шигтгээ 4.	Зөрчлийн хэргийн материалаас	37
Шигтгээ 5.	Зөрчлийн хэргийн материалаас	37
Шигтгээ 6.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	41
Шигтгээ 7.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	41
Шигтгээ 8.	Прокурортой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	41
Шигтгээ 9.	Эрүүгийн 180...755 дугаартай хэргийн материалаас	41
Шигтгээ 10.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	44
Шигтгээ 11.	Прокурортой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	44
Шигтгээ 12.	НПГ 2021.07.06-ны өдрийн 246 дугаартай Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах тухай тогтоолоос	46
Шигтгээ 13.	Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	51
Шигтгээ 14.	Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	52
Шигтгээ 15.	Хохирогчтой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	54
Шигтгээ 16.	Хохирогчтой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	54
Шигтгээ 17.	Хохирогчтой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	54
Шигтгээ 18.	Хохирогчтой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	55
Шигтгээ 19.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	60
Шигтгээ 20.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	60
Шигтгээ 21.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	60
Шигтгээ 22.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	61
Шигтгээ 23.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	63
Шигтгээ 24.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	63
Шигтгээ 25.	Прокурортой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	63
Шигтгээ 26.	Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	63
Шигтгээ 27.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	65
Шигтгээ 28.	180...195 дугаартай хэргийн материалаас	67
Шигтгээ 29.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	67
Шигтгээ 30.	Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	75
Шигтгээ 31.	Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	75
Шигтгээ 32.	Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	75
Шигтгээ 33.	Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	80

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Энэхүү судалгааг Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хооронд 2020 онд байгуулсан Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээний хүрээнд Азийн сан болон Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллага (ДЗМОУБ)-ын хамтран хэрэгжүүлж буй Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд Хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийх дүн шинжилгээ сэдэвт судалгааны ажлын гүйцэтгэгчээр ХТЭТ болон түүний судлаачдын баг 2021 оны 07 дугаар сараас ажиллаж байна.

Уг судалгааг дараах зорилгын хүрээнд судлав. Үүнд:

1. Палермогийн протоколын тодорхойлолтын дагуу хүн худалдаалах гэмт хэргийн бэлгийн мөлжлөг болон албадан хөдөлмөр эрхлүүлэх, хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор насанд хүрсэн болон насанд хүрээгүй хүнийг худалдаалсан хэргүүд, шүүхээр шийдвэрлэгдсэн болон цагдаад хандсан, шалгагдсан, прокурорт хянагдсан, хэрэгсэхгүй болгосон, зүйлчлэл өөрчлөгдсөн сүүлийн 3 жилийн хугацаан дахь эрүүгийн хавтаст хэргүүдийг судлах, дүн шинжилгээ хийх, санал, зөвлөмж боловсруулах;
2. Эрүүгийн хуулийн 12.3; 12.6; 13.1; 13.13; 15.3; 16.4; 16.6; 16.8; 16.9; 16.10 зүйл ангиар зүйлчлэгдсэн хэрэг, хохирогчийг тогтоох үндэслэл, зүйлчлэл өөрчлөгдсөн эсэх, хэрэг бүртгэгдсэнээс шийдвэрлэгдэх хүртэл зарцуулсан хугацаа, ажилтны тоо, ажлын ачаалал зэргийг судлах, хохирогчид учирч буй хүндрэл, бэрхшээлийг тогтоож, цаашид хууль тогтоомжийг хохирогчид ээлтэй болгох, сайжруулах санал, зөвлөмжийг гаргах;
3. Хуулийн байгууллагад хандсан, хохирогчоор тогтоогдсон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлсэн туслалцаа дэмжлэгийн өнөөгийн нөхцөл байдал, хууль зүйн үйлчилгээнд дүн шинжилгээ хийх юм.

Судалгааны ажлын мэдээлэл цуглуулалтыг Улсын дээд шүүх, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Нийслэлийн прокурорын газар, Эрүүгийн цагдаагийн газар болон Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг дэх шүүх, прокурор, цагдаагийн болон өмгөөлөгчдийн төлөөллийг хамруулан нийт 49, хуулийн байгууллагад хандсан хүн худалдаалах гэмт хэргийн 20 хохирогч ба нийт 69 оролцогчийг хамруулан зохион байгуулав.

Тоон судалгааг цагдаа, прокурор, шүүхийн байгууллагын статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж боловсруулсан болно.

Судалгааны ажлын хүрээнд дараах үр дүнг тодорхойлов. Үүнд:

### **1. Эрх зүйн зохицуулалтын чиглэлээр**

- ☉ **Үр дүн 1.** Хэдийгээр манай улс хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч хамгааллын чиглэлээр 12 олон улсын баримт бичигт нэгдэж, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байна. Харин энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгддэг, үйлдэгдэж болзошгүй улс орнуудтай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг байгуулах шаардлагатай байна.
- ☉ **Үр дүн 2.** Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, хүн худалдаалахтай тэмцэх бие даасан хуулийг баталсны зэрэгцээ салбар хуулиар тодорхой асуудлуудыг зохицуулсан байна. Гэвч өнөөдрийг хүртэл бие даасан хуульд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдээгүй байна.

### **2. Зөрчил шалгаж шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр**

- ☉ **Үр дүн 3.** Биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон зөрчил буурах хандлагатай байгаа ч энэ цар тахлын нөхцөл байдлын улмаас тогтоосон хориглолт, хязгаарлалттай холбоотой байна.
- ☉ **Үр дүн 4.** Биеэ үнэлэхийг зохион байгуулсан, зуучилсан гэж торгох шийтгэл хүлээсэн хүмүүсийн олонх нь эмэгтэйчүүд бөгөөд тэдний зарим нь энэ төрлийн зөрчлийг хэд хэдэн удаа үйлдэж байсан байна.
- ☉ **Үр дүн 5.** Биеэ үнэлэх, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орох / биеэ үнэлэхийг зохион байгуулах/ зөрчлийг хялбаршуулсан журмаар шалгаж, шийдвэрлэх явдал түгээмэл байна.

### **3. Мөрдөн шалгах ажиллагааны чиглэлээр**

- ☉ **Үр дүн 6.** Цагдаагийн байгууллагын бүтцэд ХХГХ болон Хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг мөрдөх бие даасан нэгж байгуулагдсан нь сайшаалтай байна.
- ☉ **Үр дүн 7.** ХХГХ болон түүнтэй төстэй гэмт хэрэг, ялангуяа хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд оруулах замаар гэмт хэргийн хохирогч болгох явдал тогтвортойгоор өсөх хандлагатай байна.
- ☉ **Үр дүн 8.** Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж байгаа ч гомдол, мэдээллийг шалгах ажиллагааны төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.
- ☉ **Үр дүн 9.** ХХГХ, түүнтэй төстэй гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгаад, хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах ажиллагаанд Эрүүгийн хуульд ХХГХ-ийн хэлбэр бүрийг тусгайлан бие даасан гэмт хэрэг болгож зохицуулсан нь сөргөөр нөлөөлөх хандлагатай байна.

- ☞ **Үр дүн 10.** Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэгт өртөж хохирсон иргэд нэн тэргүүнд хуулийн байгууллагад гэхээсээ илүүтэй төрийн бус байгууллагад хандаж туслалцаа дэмжлэг авах хандлагатай байна. Энэ нь хуулийн байгууллагад итгэх итгэлгүйн дээр тэдний харилцаа хандлагатай зарим талаараа хамааралтай байна.
- ☞ **Үр дүн 11.** Энэ төрлийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах хугацаа харилцан адилгүй байна. Энэ нь тухайн хэргийн нөхцөл байдал, оролцогчдын тоо, нотлох ажиллагааны цар хүрээ болон бүртгэгдэх үедээ гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тогтоогдсон байсан эсэхтэй шууд хамааралтай байна.
- ☞ **Үр дүн 12.** Мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогчдоос хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах, өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах, мэдээллээр хангуулах, аюулгүй байдлаа хамгаалуулах боломж хязгаарлагдмал байна.
- ☞ **Үр дүн 13.** ХХГХ болон түүнтэй төстэй хэргийн хохирогчид өөрт учирсан хохирлоо тодорхойлох, түүнтэй холбоотой баримтыг хэрхэн гаргах, ямар байдлаар нөхөн төлүүлж болох талаар мэдлэг, ойлголтгүйн улмаас хохирлоо нэхэмжилж чадахгүй байна.

#### ***4. Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр***

- ☞ **Үр дүн 14.** Шүүхээс хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийг шийдвэрлэж буй тоон үзүүлэлт жил бүр өсч байгаа нь сайн үзүүлэлт юм. Гэвч энэ нь нийт бүртгэгдсэн, шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн тоотой харьцуулахад цөөн байна.
- ☞ **Үр дүн 15.** Шүүхийн байгууллагад ХХГХ, түүнтэй төстэй хэргийг дагнан шийдвэрлэх шүүгч байхгүй ч ийм төрлийн дагнасан шүүгч ажиллах хэрэгцээ шаардлага одоогоор байхгүй гэж шүүгч нар үзэж байна.
- ☞ **Үр дүн 16.** Шүүхээс ХХГХ болон түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх хугацаа харилцан адилгүй байна.
- ☞ **Үр дүн 17.** Шүүхийн практикт хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчид бодит мөнгөн дүнгийн хохирол нэхэмжлэхээс илүүтэй сэтгэл санааны, бие эрхтэнд учирсан хор уршгийн талаар хохирол нэхэмжлэх хандлагатай байдаг байна.
- ☞ **Үр дүн 18.** Эрүүгийн хуульд хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэрэгт оногдуулах хорих ялын интервал харьцангуй урт байна. Өөрөөр хэлбэл нэг гэмт хэрэгт ял шийтгэгдэж байгаа этгээдүүд хоорондоо харилцан адилгүй ял шийтгэгдэх боломжийг хуулиар бий болгосон байна.

## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийх зөвлөх багийн ажлын даалгаварт заасан дараах зорилго, зорилтыг хангахад чиглэгдсэн. Үүнд:

*Хүснэгт 1. Судалгааны зорилго, зорилтууд*

	Зорилго	Зорилт
Нэг	Палермогийн протоколын тодорхойлолтын дагуу хүн худалдаалах гэмт хэргийн бэлгийн мөлжлөг болон албадан хөдөлмөр эрхлүүлэх, хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор насанд хүрсэн болон насанд хүрээгүй хүнийг худалдаалсан хэргүүд, шүүхээр шийдвэрлэгдсэн болон цагдаад хандсан, шалгагдсан, прокурорт хянагдсан, хэрэгсэхгүй болгосон, зүйлчлэл өөрчлөгдсөн сүүлийн 3 жилийн хугацаан дахь эрүүгийн хавтаст хэргүүдийг судлах, дүн шинжилгээ хийх, санал, зөвлөмж боловсруулах;	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргүүдтэй холбоотой өргөдөл, гомдлыг бүртгэл, хэрэгсэхгүй, түдгэлзсэн хэргийн талаарх сүүлийн 3 жилийн статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх;</li> <li>✓ Хүн худалдаалах, түүнтэй төстэй эрүүгийн хэргийг бүртгэх, хянан шалгах, эцэслэн шийдвэрлэсэн, хэргийн зүйчлэл өөрчлөгдсөн байдалд дүн шинжилгээ хийх;</li> <li>✓ Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаа, хэргийн оролцогч талуудын ажлын ачаалал, хүний нөөц, хүртээмжийг тодруулах.</li> </ul>
Хоёр	Эрүүгийн хуулийн 12.3; 12.6; 13.1; 13.13; 15.3; 16.4; 16.6; 16.8; 16.9; 16.10 зүйл ангиар зүйлчлэгдсэн хэрэг, хохирогчийг тогтоох үндэслэл, зүйлчлэл өөрчлөгдсөн эсэх, хэрэг бүртгэгдсэнээс шийдвэрлэгдэх хүртэл зарцуулсан хугацаа, ажилтны тоо, ажлын ачаалал зэргийг судлах, хохирогчид учирч буй хүндрэл, бэрхшээлийг тогтоож, цаашид хууль тогтоомжийг хохирогчид ээлтэй болгох, сайжруулах санал, зөвлөмжийг гаргах;	<ul style="list-style-type: none"> <li>✓ Өргөдөл, гомдол хүлээн авахаас эцэслэн шийдвэрлэж дуусах үе шат хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үйл явцыг тодруулах;</li> <li>✓ Бүртгэгдсэн эрүүгийн хэргийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх.</li> </ul>

Гурав	Хуулийн байгууллагад хандсан, хохирогчоор тогтоогдсон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлсэн туслалцаа дэмжлэгийн өнөөгийн нөхцөл байдал, хууль зүйн үйлчилгээнд дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хохирогчдын хуулийн байгууллагад хандсан хугацаа, тэдний гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан эсэх, хүлээн авсан боловч хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн үндэслэлийг тогтоох;</li> <li>✓ Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл зарцуулсан хугацааг тодорхойлох;</li> <li>✓ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийг төлөөлж оролцож буй мөрдөгч, прокурор, шүүгчид өөрчлөгдсөн үндэслэн, шалтгааныг тодорхойлох;</li> <li>✓ Хохирогчийн өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангасан байдалд дүн шинжилгээ хийх;</li> <li>✓ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тэднийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилсан эсэхийг тодорхойлох;</li> <li>✓ Хохирогчдоос хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход тулгарч байсан хүндрэл бэрхшээлийг тодруулж, хэрхэн даван туулж байсныг тодорхойлох;</li> <li>✓ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн харилцаа, хандлага, ажлын хурд, хохирогчийг мэдээллээр хангаж буй байдлыг үнэлэх.</li> </ul>
-------	--	--


Дээрх зорилтуудын хүрээнд судалгааны тайланг дараах бүлгийн хүрээнд боловсрууллаа. Үүнд:

1. Хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэрэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалт
2. Хүн худалдаалах болон түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн байдлын талаар авч үзэж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Судалгааны ажлын даалгаварт заасан зорилтуудад хүрэхийн тулд судалгааны баг тоон болон чанарын аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулан шинжилгээ хийв.

Зураг 1. Судалгааны арга зүй



**Тоон мэдээлэл:** Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ), Улсын ерөнхий прокурорын газар (УЕПГ), Цагдаагийн ерөнхий газрын (ЦЕГ) статистик, мэдээллийг нэгтгэн дүгнэх замаар, хэргийн хөдөлгөөнийг зураглах, процессын үед гарч буй хүндрэл бэрхшээлийг бататгахад ашигласан. Ийнхүү шаардлагатай мэдээллийг ХЗДХЯ-ны дэргэдэх ГХУСАЗЗ-ийн ажлын албаар уламжлуулан шаардлагатай мэдээллүүдийг гаргуулан авлаа.

**Чанарын судалгаа:** Чанарын судалгааны хүрээнд хоёр төрлийн аргаар мэдээлэл цуглуулалтыг хийж гүйцэтгэсэн. Үүнд баримт бичгийн судалгааг сэдвийн судлах шаардлагатай олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичиг, холбогдох ижил төстэй судалгаа зэрэг мэдээллүүдийг цуглуулж, нэгтгэн авч үзсэн. Түүнчлэн шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн ХХГХ болон түүнтэй



төстэй хэрэг, Зөрчлийн тухай хуулийн 6.18.4<sup>1</sup>, 6.18.7<sup>2</sup> дугаар зүйлд заасан зөрчлийн хэргийг шалгаж, шийдвэрлэсэн материал зэрэгтэй танилцаж, дүн шинжилгээ хийв.

Захиалагчаас ирүүлсэн саналын дагуу мэдээлэл цуглуулалтыг Улсын дээд шүүх, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Нийслэлийн прокурорын газар, Эрүүгийн цагдаагийн газар болон Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг дэх шүүх, прокурор, цагдаагийн болон өмгөөлөгчдийн төлөөллийг хамруулан нийт 49, хуулийн байгууллагад хандсан хүн худалдаалах гэмт хэргийн 20 хохирогч ба нийт 69 оролцогчийг хамруулав.

Судалгааны явцад зарим дүүргүүдэд энэ төрлийн гэмт хэрэг мөрдөн шалгах, шүүхээр шийдвэрлэгдсэн тохиолдол байгаагүйгээс мэдээлэл цуглуулалтыг оролцогч талын оролцооны тоонд багтаан зарим өөрчлөлт тодотголуудыг оруулсан болно.

*Хүснэгт 2. Чанарын ярилцлагад оролцсон оролцогчдын тоо*

	Шүүх	Прокурор	Цагдаа	Өмгөөлөгч	Хохирогч
Улсын дээд шүүх	1				
Нийслэлийн шүүх/ прокурор	3	10			
Эрүүгийн цагдаагийн алба			3		
Мөрдөн байцаах алба			2		
Сүхбаатар дүүрэг	1	1			
Баянзүрх дүүрэг	1		2		
Хан уул дүүрэг	2				
Чингэлтэй дүүрэг	1		2		
Сонгинохайрхан дүүрэг	2	2	2		
Баянгол дүүрэг	3		4		
Налайх дүүрэг		1			
<b>Нийт оролцогч</b>	<b>14</b>	<b>14</b>	<b>15</b>	<b>6</b>	<b>20</b>


Цагдаагийн байгууллагаас оролцсон нийт 15 оролцогчийн 8 буюу 53.3 хувь нь хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, прокурорын байгууллагаас оролцсон нийт 14 прокурорын 8 буюу 57.1% нь прокурорын хяналт тавьж байсан туршлагатай оролцогчид байсан

<sup>1</sup> Зөрчлийн тухай хуулийн 16.18.4 дэх зүйлд биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, эсхүл бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

<sup>2</sup> Зөрчлийн тухай хуулийн 16.18.7 дах зүйл заалт 2020 оны нэмэлт өөрчлөлтөөр хүчингүйд тооцсон. Мөн онд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.6 дугаар зүйлийг нэмж, Биеэ үнэлэхийг зохион байгуулах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр шийдвэрлэжээ.

бол судалгаанд хамрагдсан бүх шүүгч энэ төрлийн гэмт хэргийн шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байсан байна. Харин өмгөөлөгчдийн 3 буюу 50% нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болон яллагдагч, шүүгдэгчид хууль зүйн туслалцаа үзүүлж байжээ.


Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын хүйсийн мэдээлэл



Судалгаанд оролцсон цагдаа, прокурор, шүүх, өмгөөлөгчдийн төлөөллийн 38.7 хувь нь эмэгтэй болон хуулийн байгууллагад хандсан 20 хохирогч бүгд эмэгтэй байлаа.

Шүүх болон өмгөөллийн байгууллагын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа тэнцвэртэй байсан бол прокурорын байгууллагаас эрэгтэй албан хаагч илүү түлхүү оролцжээ.


Зураг 2. Хохирогчдын насны байдал




Зураг 3. Хохирогчдын амьдарч буй байршил



Зураг 4. Хохирогчдын боловсрол



Зураг 5. Хохирогчдын гэр бүлийн байдал



Судалгааны үр дүнг баталгаажуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хохирогч-төвтэй явагдаж байгаа эсэх, хохирогчид үзүүлж буй үйлчилгээний үр дүнг үнэлэх зорилгоор санамсаргүй түүврийн аргаар 20 хохирогчийг сонгон авсан бөгөөд эдгээр оролцогчид нь бүгд цагдаагийн байгууллагад гомдлоо гаргаж, мөрдөгч, прокурорын тогтоолоор хохирогчоор тогтоосон онцлогтой.

Хохирогчдын хувийн байдлыг авч үзвэл гэмт хэрэгт өртөж хохирох үедээ насанд хүрээгүй байсан 13, насанд хүрсэн 7, нийт 20 хохирогч байв. Насны бүтцийн хувьд гэмт хэргийн хохирогчоор тогтоогдох үедээ насанд хүрээгүй 4, 19-24 настай байсан 11, 25-30 настай байсан 4, 31-аас дээш настай байсан 1 хүн байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт 16-25 насны хүмүүс өртөж хохирох нь их байгааг харуулж байна. Эдгээр оролцогчдын 11 нь бага ба бүрэн бус дунд боловсролтой, 11 нь өрх толгойлсон эх байгаа нь анхаарал татаж байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдал, Монгол Улсын Засгийн газраас тогтоосон өндөржүүлсэн байдлын зэрэг буураагүй, халдвар тархалтын нөхцөл байдал зэргийг харгалзан оролцогчидтой ганцаарчилсан болон цахим уулзалтыг зохион байгуулж, мэдээлэл цуглуулалтыг зохион байгуулсан. Ганцаарчилсан ярилцлагын удирдамжийн төслийг багийн гишүүн тус бүр боловсруулан захиалагч болон ГХУСАЗЗ-ийн ажлын албаны мэргэжилтэнд хүргүүлэн санал авч эцэслэсэн болно.

**Баримт бичгийн судалгаа:** Баримт бичгийн судалгааны хүрээнд дараах үндсэн дөрвөн төрлийн ялгаатай бичиг баримтад шинжилгээ хийсэн.

- ✓ **Эрх зүйн баримт бичиг** - Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын болон үндэсний хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, холбогдох журам зэрэг нийт 20 гаруй эрх зүйн баримт бичигтэй танилцсан.
- ✓ **Судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл** - ХХГХ болон түүнтэй төстэй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр дотоодод хийгдсэн судалгааны тайлангуудтай танилцсан.

- ✓ **Эрүүгийн хэргийн материал** - УЕПГ-ын дэргэдэх Эрүүгийн хэргийн төв архивт хадгалагдаж байгаа, 2018 оноос хойш Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд зааснаар шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн 4 хэргийн материалтай танилцаж, дүн шинжилгээ хийв.
- ✓ **Зөрчлийн хэргийн материал** - Зөрчлийн тухай хуулийн 6.18.4, 6.18.7 /2021 оны 1 сараас гэмт хэрэгт тооцогдсон/ дугаар зүйлд заасан зөрчлийн хэргийг шалгаж, шийдвэрлэсэн 16 материалтай танилцаж, дүн шинжилгээ хийв.

## МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ ЯВЦАД ГАРСАН ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, ДАВАН ТУУЛСАН БАЙДАЛ, СУРГАМЖ

ХХГХ нь нуугдмал, зохион байгуулалттай үйлдэгддэг гэмт хэрэг тул энэхүү судалгаа нь арга зүй, хэрэглэгдэхүүний агуулгын хувьд тодорхой хүрээнд хязгаарлагдах нь зайлшгүй. Судалгааны мэдээлэл цуглуулалтын явцад дараах бэрхшээл тулгарч байсан ч бид тухай бүрд даван туулах бүхий л арга замыг эрэлхийлж шийдвэрлэж ажилласан болно.

- ✓ **Эрх зүйн орчны хязгаарлалт:** Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.4 дэх хэсэгт шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа хэрэг, маргааны талаар шүүхийн шийдвэр гарахаас өмнө өөрийн байр суурийг олон нийтэд мэдээлэх, илэрхийлэх, 50.1.6 дахь хэсэгт бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн аливаа мэдээллийг шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өөр зорилгоор ашиглахыг хориглосон нь шүүгч нараас ганцаарчилсан ярилцлагад орохоос татгалзах шалтгаан болж байсан ч бид шүүхээр эцэслэн шийдэгдээгүй хэрэг болон бодит хэргийн нөхцөл байдлын талаар бус тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудлыг тодруулах зорилгоо сайтар тайлбарласнаар ярилцлагыг түүврийн хэмжээнд хийж чадсан.
- ✓ **Судалгаанд оролцогчдын мэдлэг, ойлголт:** Судалгаанд нийт 45 оролцогч оролцсон бөгөөд судалгааны баг аль болох ХХГХ болон түүнтэй төстэй хэрэг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд оролцож байсан шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгчийг оролцуулахыг зорьсон. Гэвч цагдаагийн байгууллагаас ярилцлагад оруулахаар санал болгож ирүүлсэн алба хаагчдын дунд тухайн албан тушаалд томилогдоод 1-6 сарын хугацаа өнгөрч байгаа нэлээдгүй алба хаагч байсан нь ярилцлагын үр дүнд нөлөөлөхүйц байдлыг бий болгосон. Түүнчлэн Мөрдөн байцаах албаны Хүүхдийн эсрэг үйлдсэн болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэс нь 2021 онд байгуулагдсан бөгөөд алба хаагчид нь бүгд шинээр томилогдсон, өмнө нь энэ төрлийн гэмт хэрэг шалгаж, шийдвэрлэж байгаагүй зэрэг нөхцөл байдалтай тулгарсан.
- ✓ **Хохирогчдын эрх зүйн мэдлэгийн дутмаг байдал:** нь хохирогчоор тогтоогдсон хэргийн явц, шийдвэрлэлтийг тодруулах, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудын ажилласан байдалд анализ хийх, үйлчилгээний сэтгэл ханамжийг үнэлэхэд үйлчилгээний ялгаа, арга зүйд дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байдлыг бий болгож байв.
- ✓ **Цаг үеийн нөхцөл байдлын нөлөө:** Тус судалгааны ажлын мэдээлэл цуглуулалт нь 2021 оны 07, 08-р сард зохион байгуулагдсан. Энэ нь төрийн албан хаагчдын амралтын үетэй

давхацсан тул олон жил ажилласан, дадлага туршлагатай оролцогчийг сонгон ярилцлага хийх боломжийг хязгаарласан.

- ✓ **Төрийн байгууллагын мэдээллийн ил тод бус байдал:** Судалгааны ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор цагдаа, прокурор, шүүхийн байгууллагаас тоон мэдээлэл цуглуулсан. Тоон мэдээлэл цуглуулахад ялангуяа эрүүгийн хэргийн хөдөлгөөний судалгаа, хэргийн хохирогч /насанд хүрсэн, насанд хүрээгүйгээр нь ялгаж/-ийн тоон мэдээлэл, хэргийн шийдвэрлэлтийн байдал түүн дотроо хэрэгсэхгүй болгосон, түдгэлзүүлсэн, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан үндэслэлийн талаарх мэдээлэл цуглуулалт удаашралтай, гаргаж өгсөн мэдээлэл нь дутуу бөгөөд судалгаанд ашиглагдахгүй байх тохиолдол элбэг байв.
- ✓ **Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдал:** Монгол Улсын Засгийн газраас тогтоосон өндөржүүлсэн байдлын зэрэг буураагүй, халдварын тархалтын нөхцөл байдал зэргийг харгалзан оролцогчидтой ганцаарчилсан болон цахим уулзалтыг зохион байгуулж, мэдээлэл цуглуулалтыг явууллаа.

Хэдийгээр ийм асуудлууд тулгарсан ч энэ нь судалгааны үр дүнд нөлөөлөөгүй болохыг судалгааны багийн зүгээс тэмдэглэж байна.

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

## ХҮН ХУДАЛДААЛАХ БОЛОН ТҮҮНТЭЙ ТӨСТЭЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ<sup>3</sup>

### 1.1. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Үр дүн 1. Хэдийгээр манай улс хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч хамгааллын чиглэлээр 12 олон улсын баримт бичигт нэгдэж, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байна. Харин энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгддэг, үйлдэгдэж болзошгүй улс орнуудтай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг байгуулах шаардлагатай байна.*

Их Британид 1807 онд боолчлолын эсрэг анхны хууль батлагдсан нь дэлхийн олон оронд боолчлол, боолын худалдаа болон охид, эмэгтэйчүүд, хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах явдалтай тэмцэх анхны алхам болсон гэж судлаачид үздэг байна. Өнөөдрийн байдлаар ХХГХ болон түүнтэй төстэй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч хамгаалах чиглэлээр НҮБ болон түүний байгууллагуудаас олон улсын хэмжээний 15 орчим бичиг баримт батлан гаргасны 12-т нь Монгол Улс нэгдэн орсон байна.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын гол бичиг баримт нь 2000 оны 11 дүгээр сарын 15-нд батлагдсан, манай улс 2008 оны 05 дугаар сарын 16-нд УИХ-аар соёрхон баталсныг 2008 оны 06 дугаар сарын 27-нд НҮБ-д бүртгэж авсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол (цаашид Палермогийн протокол гэх) юм.<sup>4</sup>

Уг протоколын 3-р зүйлд Хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлохдоо:

- a. Хүн худалдаалах гэмт хэрэг гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ. Хүнийг мөлжих гэдэгт биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй төстэй нөхцөлд байлгах, эд эрхтэнийг нь авах үйлдлийг ойлгоно.

<sup>3</sup> Хэдийгээр ажлын даалгаварт эрх зүйн зохицуулалттай холбоотой асуудал тусгагдаагүй ч энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх чиглэлд ямар эрх зүйн зохицуулалтууд буйг мэдээлэл, дүн шинжилгээ хэлбэрээр хүргэж байгаа болно.

<sup>4</sup> Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц ба түүний протокол

- b. Дээрх аргуудын аль нэгийг ашигласан тохиолдолд хохирогч өөрийг нь дээр дурдсан аргаар мөлжих гэж байгааг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.
- c. Мөлжих зорилгоор хүүхдийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авсан аливаа үйлдэл нь дээр дурдсан аргаар үйлдсэн байхыг шаардахгүйгээр хүн худалдаалах гэмт хэрэгт тооцно гэжээ.

Монгол Улсад 2000 оны эхээр өрнөсөн эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд батлагдсан 2002 оны Эрүүгийн шинэ хуулийн 113 дугаар зүйлд “Хүн худалдах, худалдан авах” гэмт хэргийг шинээр тусгасан. Улмаар, 2008 онд Палермогийн протоколд нэгдэн орсонтой холбоотойгоор тухайн үед мөрдөгдөж байсан Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг эхлүүлж, 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд, Хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг хуульчлахдаа протоколын агуулгыг нарийвчлан тусгаж, зөрчилдөөнгүй болгосон нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүйн нэг том алхам болсон гэж үздэг.

*Хүснэгт 4. Палермогийн протокол болон  
Монгол Улсын Эрүүгийн хуулийн харьцуулалт*

<b>НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт Палермогийн протокол</b>	<b>Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/</b>
“Хүн худалдаалах” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ.	Хүн худалдаалах гэдэг нь “Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтэнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг хэлнэ.
<b>ХХГХ-ийн шинжийн дагуу дээрх хоёр тодорхойлолтыг нарийвчлан задалбал:</b>	
<b>Зорилго</b> Хүнийг мөлжих зорилгоор	<b>Зорилго</b> Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтэнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор



<p><b>Үйлдлийн арга</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах,</li> <li>• хулгайлах,</li> <li>• залилах,</li> <li>• хууран мэхлэх,</li> <li>• эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах,</li> <li>• эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах</li> </ul>	<p><b>Үйлдлийн арга</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• хүч хэрэглэх</li> <li>• хүч хэрэглэхээр заналхийлэх</li> <li>• хулгайлах</li> <li>• хууран мэхлэх</li> <li>• итгэл эвдэх</li> <li>• эрх мэдлээ урвуулах</li> <li>• эмзэг байдлыг нь далимдуулах</li> <li>• хяналтдаа байлгаж байгаа хүнд нь төлбөр төлж, хахуульдах</li> </ul>
<p><b>Үйлдэл</b> хүмүүсийг урвуулан элсүүлэх; тээвэрлэх; дамжуулах; нуугдуулах буюу хүлээж авах.</p>	<p><b>Үйлдэл</b> элсүүлэх; тээвэрлэх; орогнуулах; дамжуулах; хүлээн авах.</p>

Монгол Улсын Эрүүгийн хуульд ХХГХ-ийн талаар заасан зохицуулалт нь Палермогийн протоколын тодорхойлолттой агуулгын хувьд бүрэн нийцсэн болох нь харагдаж байна. Гэвч Эрүүгийн хуульд ХХГХ-ийн төрөл хэлбэрүүдийг бие даасан гэмт хэрэг болгон давхар зохицуулсан. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд Хүн худалдаалах гэмт хэрэгт бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих, эд эрхтэнийг авах зэрэг үйлдэл нь ХХГХ-ийн хэлбэр болохоор заасан, хүүхдийн эсрэг ХХГХ-ийг үйлдсэн бол ямар аргаар үйлдсэн байх нь хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй байхаар тайлбарласан ч ХХГХ-ийн хэлбэрүүдийг бие даасан байдлаар хуульчилжээ<sup>5</sup>.

*Хүснэгт 5. Монгол Улсын нэгдэн орсон хүн худалдаалахтай тэмцэх чиглэлийн Олон улсын гэрээ, конвенцын жагсаалт<sup>6</sup>*

№	Гэрээ, конвенцын нэр	Батлагдсан	Хүчин төгөлдөр болсон	Монгол Улс нэгдэн орсон
1.	Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын 29-р конвенц	1930.06.28	1932.05.01	2005.03.15
2.	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	1945.06.26	1945.10.24	1961.10.27
3.	Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенц	1956.09.07	1957.04.30	1968.10.31
4.	Албадан хөдөлмөрийг устгах тухай ОУХБ-ын 105-р конвенц	1957.06.25	1959.01.17	2005.03.15
5.	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	1979.12.18	1981.09.03	1981.07.20

<sup>5</sup> Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2015, №7, 12.3, 12.6, 13.13, 15.3, 16.4, 16.6, 16.8, 16.9, 16.10 дугаар зүйл

<sup>6</sup> <http://mfa.gov.mn/#>

6.	Хүүхдийн эрхийн тухай конвенц	1989.11.20	1990.09.02	1990.01.26
7.	Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц	1993.05.29	1995.05.01	2000.04.25
8.	Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэм	1998.07.18	2002. 07.01	2002.04.05
9.	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182-р конвенц	1999.06.17	2000.11.19	2001.02.26
10.	Хүүхдийн эрхийн конвенцын нэмэлт Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протокол	2000.05.25	2002.01.18	2001.11.12
11.	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц	2000.11.15	2003.09.29	2008.05.16
12.	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын нэмэлт Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол	2000.11.15	2003.12.25	2008.05.16

Гадаад харилцааны яамны мэдээллээр Монгол Улс 2020 оны байдлаар 300 орчим олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсон бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 193 дугаар тогтоолоор “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам”-ыг баталсан<sup>7</sup>. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлийн дараах олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн тайлан, түүнийг хариуцан гаргах эрх бүхий байгууллагыг тогтоосон байна. Үүнд:

1. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, түүний протокол
2. Албадан хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 29 дүгээр конвенц
3. Хүүхдийн эрхийн тухай конвенц
4. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол
5. Хүүхдийн эрхийн тухай конвенцын нэмэлт мэдээлэл хүргүүлэх журмын тухай III протокол

UNODC буюу НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газраас өмнө нь Палермо протоколын хэрэгжилтийн тайланг авдаггүй байсан боловч 2021 онд анх удаагаа гишүүн орнуудаас протоколын хэрэгжилтийн тайланг гаргуулжавахаар болсон тул ХЗДХЯ-ндажлын хэсэг ажиллаж байна. Гэвч Монгол Улсын нэгдсэн орсон гэрээ, конвенцын хэрэгжилтийг тайлагнах хуваарь,

<sup>7</sup> <https://legalinfo.mn/main/detail/12817>

хариуцах байгууллагыг баталсан дээрх тогтоолд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, түүний нэмэлт протоколын хэрэгжилттэй холбоотой бие даасан тайланг боловсруулах хуваарь, хариуцах байгууллагыг гаргаж өгөөгүй байгааг анхаарах шаардлагатай болжээ.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь үндэстэн дамнаж үйлдэгддэг онцлогтой бөгөөд нийгмийн хор аюулын шинж чанараар үлэмж их хор хохирол учруулдаг гэмт хэрэг. Энэ төрлийн ялангуяа хил дамнан үйлдэгдсэн гэмт хэрэгт гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, туршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын гэрээ байгуулсан байх шаардлага үүснэ.

Манай улсын тухайд нийт 17 улстай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр гэрээ байгуулсан бөгөөд үүнийг судлаачдын зүгээс чамлалттай гэж үзэж байгаа юм.

*Хүснэгт 6. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэхээр гэрээ байгуулсан улс орны жагсаалт*

№	Гэрээ байгуулсан улс	Гэрээний огноо
1.	Бүгд Найрамдах Франц Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	тодорхойгүй
2.	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	тодорхойгүй
3.	Бүгд Найрамдах Унгар Ард Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	1968.11.22
4.	Бүгд Найрамдах Болгар Ард Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	1968.11.27
5.	Бүгд найрамдах ардчилсан Герман улстай байгуулсан иргэний болон гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ	1969.04.30
6.	Бүгд Найрамдах Социалист Румын Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	1972.11.25
7.	Бүгд Найрамдах Социалист Чехословак Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	1976.10.15
8.	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	1988.10.29

9.	Бүгд Найрамдах Хятад Ард Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	1989.08.31
10.	Бүгд Найрамдах Казахстан Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	1993.10.22
11.	Украйн Улстай байгуулсан иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	1995.06.27
12.	Оросын Холбооны Улстай байгуулсан иргэний ба эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	1999.04.20
13.	Бүгд Найрамдах Польш Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	1999.07.09
14.	Бүгд Найрамдах Солонгос Улстай байгуулсан иргэний болон худалдааны хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	1999.07.21
15.	Бүгд Найрамдах Турк Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	2000.05.02
16.	Бүгд Найрамдах Киргиз Улстай байгуулсан эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	2000.12.04
17.	Бүгд Найрамдах Энэтхэг Улстай байгуулсан иргэний ба аж ахуйн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ	2001.01.03

АНУ-ын Элчин сайдын яамны Хүн наймаалах асуудлын төлөв байдал - 2019 тайланд Монголын насанд хүрсэн, насанд хүрээгүй хүүхдүүдийг албадан хөдөлмөрлүүлэхээр Хятад, Казакстан, Норвеги, Швед, Турк улсуудад, харин бэлгийн мөлжлөгт ашиглахаар Бельги, Камбож, Хятад, Герман, Хонконг, Япон, Макао, Малайз, Өмнөд Солонгос, Швед, Турк, АНУ руу худалдаалж байгаа талаар мэдэгдэж байв. Харин Хүн наймаалах асуудлын төлөв байдал-2021 тайланд “сүүлийн 5 жилийн хугацаанд тайлагнасанчлан хүн худалдаалах гэмт хэрэгтнүүд Монгол Улсын нутаг дэвсгэрт дотоод, гадаадын хохирогчдыг мөлжиж, мөн хилийн чанадад монголчуудыг мөлжлөгт оруулж байна. Гэмт этгээдүүд албадан хөдөлмөр эрхлэлт болон бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон гадаад иргэдийг Монгол Улсаар дамжуулан Орос, Хятад зэрэг улс руу худалдаалдаг байж болзошгүй байна. Монголын эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хүүхдүүдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхээр Хятад, Энэтхэг, Казакстан, Норвеги, Швед, Турк болон Арабын Нэгдсэн Эмират улсуудад, харин бэлгийн мөлжлөгт ашиглахаар Бельги, Камбож, Хятад, Герман, Хонконг, Япон, Макао, Малайз, Филиппин, Өмнөд Солонгос, Швед, Турк, АНУ руу болон Монголд дотооддоо худалдаж байна” гэжээ. Эндээс үзвэл манай улсын иргэдийг албадан хөдөлмөрлүүлэхээр Энэтхэг, Арабын Нэгдсэн Эмират болон бэлгийн

мөлжлөгт ашиглахаар Филиппин улс руу илгээх шинэ урсгал нээгдсэн байж болзошгүй нь харагдаж байна.

Мөн тайланд ХТЭТ-ийн мэдээгээр сүүлийн 6 жилийн хугацаанд БНХАУ, Казакстан, Турк, Малайз, Филиппин, Макао, Камбож, БНСУ, Украин, Хонгконг гэсэн 10 улсаас 293 хохирогчийг эгүүлэн авчирсан тухай тус тус дурджээ.

Иймээс гэмт хэрэг, ялангуяа үндэстэн дамнасан гэмт хэрэг үйлдэгдэж буй гадаадын улстай энэ гэрээг зайлшгүй байгуулах шаардлагатай нь ажиглагдаж байна.

---

*2010 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) Макаогийн засаг захиргааны онцгой бүсийн Засгийн газартай “Хүн худалдаалахтай тэмцэх асуудлаар хамтран ажиллах тухай” хэлэлцээр, 2011 онд БНХАУ-тай “Гэмт хэрэгтэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай” хэлэлцээр, Дорноговь аймгийн Цагдаагийн газар, БНХАУ-ын Эрээн хотын Цагдаагийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг, 2017 онд Монгол Улсын Цагдаагийн Ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба болон БНХАУ-ын ӨМӨЗО-ы Нийгмийг аюулаас хамгаалах тэнхим хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус байгуулсан.*

---

## **1.2. ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

***Үр дүн 2. Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, хүн худалдаалахтай тэмцэх бие даасан хуулийг баталсны зэрэгцээ салбар хуулиар тодорхой асуудлуудыг зохицуулсан байна. Гэвч өнөөдрийг хүртэл бие даасан хуульд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдээгүй байна.***

1986 оны Монгол Улсын Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлд 1996 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр “Хууран мэхлэх аргаар хүмүүс элсүүлэх” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг шинээр баталсан нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүйн тэмцлийн эхлэл байсан гэж судлаачид<sup>8</sup> үздэг. Түүнчлэн 2002 оны Эрүүгийн шинэ хуулийн 113 дугаар зүйлд “Хүн худалдах, худалдан авах” гэмт хэргийг шинээр тусгасан. Ийнхүү Эрүүгийн хуульд бие даасан анхны зохицуулалт болж орсон хэдий ч хүн худалдах, худалдан авах гэмт хэрэг үйлдсэн этгээд хүнийг мөлжих зорилгоор худалдаалахдаа элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах гэсэн 5 үе шатыг заавал дамжсан байхыг шаардсан нь энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдэж, шалгагдахгүй байх нөхцөлийг бий болгож байжээ.

Харин 2008 оны 05 дугаар сарын 16-нд НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас батлан гаргасан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх

---

<sup>8</sup> Ж.Нямдулам, Хүн худалдаалах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, Магистрын зэрэг горилсон судалгааны ажил, УБ.,2006, Б.Батзориг, Н.Баясгаланбат, С.Гантулга, Хүн худалдаалах гэмт хэрэг, УБ.,2009 С.Гантулга, Хүн худалдаалах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын үечлэлийн асуудал, Хууль сахиулахуй сэтгүүл, УБ.,2014, №2

тухай” протоколд Монгол Улс нэгдэн орсонтой холбоотойгоор тухайн үед мөрдөгдөж байсан Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл болон шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэргийн агуулгыг конвенцын заалттай зөрчилдөөнгүй болгосон нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүйн орчинд том алхам болсон. Түүнчлэн конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлж, 2012 онд Монгол Улсын Их Хурлаас /цаашид УИХ гэх/ Хүн худалдаалахтай тэмцэх тухай бие даасан хуулийг баталж, хэрэгжүүлж байна.

Хуулийн зорилго нь хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг нь тогтоон арилгах, хохирогчийн эрхийг хамгаалахад чиглэгдэнэ. Хуульд “хүн худалдаалах” гэж хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтэнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг хэлнэ<sup>9</sup>” гэж тодорхойлсон нь Палермогийн протоколтой нийцэж байна.

Хүн худалдаадахтай тэмцэх тухай хуульд төрийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтнууд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлэх бүрэн эрхийг тусгасан бөгөөд үүнээс гол онцлог зохицуулалт нь Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөл ажиллахаар зохицуулж, дэд зөвлөлийн хэрэгжүүлэх эрх хэмжээг зааж өгсөн явдал юм.

Мөн Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчийн нэр төр, алдар хүнд, аюулгүй байдлыг хангах, хохирогчид үзүүлэх үйлчилгээний талаар тусгаснаас гадна хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлэл өгсөн хүнийг хамгаалах асуудлыг орхигдуулаагүй нь сайшаалтай байна.

Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг нь тогтоон арилгах, хохирогчийн эрхийг хамгаалах зорилготой бие даасан хууль тогтоомжийн хэрэгжилт ямар түвшинд байгааг үнэлж дүгнэх, шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэх хамгийн гол алхам нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх явдал юм.

НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын захиалгаар Иргэдэд туслах хүний эрхийн төв 2017 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийсэн. Энэхүү судалгааны

<sup>9</sup> Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2012, №7, 3-р зүйлийн 3.1.1 дэх заалт.

үр дүнгээр “Монгол Улс нь хүн худалдаалах гэмт хэргийг Эрүүгийн хуульдаа хуульчлан хориглож, 2012 онд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдын эрхийг хамгаалах зорилго бүхий “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” бие даасан хуулийг батлан хэрэгжүүлж эхлээд байна. Гэвч хуулийн хэрэгжилт хангалтгүй, хүн худалдаалах гэмт хэрэг нь ялангуяа хөдөлмөрийн мөлжлөг, охид, эмэгтэйчүүдийн биеийг үнэлүүлэх хэлбэрээр түгээмэл үйлдэгдэж, энэхүү хэрэг нь нууц далд, зохион байгуулалттай, үндэстэн дамнан үйлдэгддэг тул хохирогчийг илрүүлэх, зөв таних ажил хангалтгүй түвшинд байна” гэж дүгнэжээ<sup>10</sup>.

УИХ-аас хууль тогтоомжийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх зорилгоор 2015 онд Хууль тогтоомжийн тухай хуулийг баталсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт зааснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлох, зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох зорилгоор хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийх бөгөөд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг Засгийн газар батлахаар заажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг баталсан. Ийнхүү хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ хийх нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршиж байна. Хэдийгээр Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд Олон улсын байгууллагын санхүүжилтээр ТББ-аас үнэлгээ хийх судалгааг хийсэн ч төр өөрийн хариуцлагаа ухамсарлаж энэ хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгааг хийх зайлшгүй шаардлагатай гэж бид үзэж байна.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.4.2-т “хүүхэд, эмэгтэйчүүд, иргэдийг хүн худалдах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгож энэ чиглэлд бэхжүүлнэ” гэж заасны дагуу 2017 онд дөрвөн жилийн хугацаатай хэрэгжих “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-г баталж, тус хөтөлбөрт “...хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэргийн хохирогчийг хамгаалах цогц үйлчилгээг бий болгох, цаашид энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох чиглэлээр төрийн

---

<sup>10</sup> Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Иргэдэд туслах хүний эрхийн төв ТББ, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа”, УБ., 2017

болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх” зорилго тавьсан нь хүний наймаатай тэмцэх хууль эрх зүйн орчин Монгол Улсад бүрдүүлэхэд чухал хувь нэмэр үзүүлжээ.

Манай улсад хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:

1. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, 1998 он
2. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, 2001 он
3. Зар сурталчилгааны тухай хууль, 2002 он
4. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, 2011 он
5. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012
6. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 2013 он
7. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, 2015 он
8. Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016 он
9. Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016 он
10. Эрүүл мэндийн тухай хууль, 2016 он
11. Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2017 он
12. Донорын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2018 он
13. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2019 он
14. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2019 он
15. Гэрч хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр, 2015 он
16. Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр, 2017 он зэрэг эрх зүйн баримт бичгүүд мөрдөгдөж байна.

Манай улсын хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч, нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцод үндэсний хууль тогтоомжоо нийцүүлэх чиглэлээр гаргасан хүчин чармайлтын дүнд эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн байна.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь зохион байгуулалттайгаар үндэстэн дамнан үйлдэгддэг тул энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судлан тогтоосны үндсэн дээр уг гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, арга хэлбэрийг шинэчлэх шаардлагатай байгааг харгалзан Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн бөгөөд 2021 онд хөтөлбөр хэрэгжиж дууссан билээ.



# ХОЁРДУГААР БҮЛЭГ

## ХҮН ХУДАЛДААЛАХ БОЛОН ТҮҮНТЭЙ ТӨСТЭЙ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

### 2.1. ЗӨРЧИЛ ШАЛГАЖ, ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

*Үр дүн 3. Биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон зөрчил буурах хандлагатай байгаа ч энэ цар тахлын нөхцөл байдлын улмаас тогтоосон хориглолт, хязгаарлалттай холбоотой байна.*

УИХ-аас 2017 онд баталсан Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.18 дугаар зүйлд Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийн талаар тухайлан зохицуулсан. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон үйлдэлд, 7 дахь хэсэгт өөрийн эзэмшлийн байр, газарт биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд зуучилсан үйлдлийг зөрчилд тооцож хариуцлага хүлээлгэхээр заажээ.

Гэвч УИХ-ын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.6 дугаар зүйлийг нэмж, Биеэ үнэлэхийг зохион байгуулах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр шийдвэрлэсэн байна<sup>11</sup>.

<sup>11</sup> Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2015, №7, 12.6 дугаар зүйл


1.Бусдыг биеэ үнэлэхэд зуучилсан, татан оролцуулсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд нь тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлээр хангасан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ гэмт хэргийг үйлдэхдээ арван найман насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн бол энэ хуульд заасан хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарна.

Зураг 6. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн Зөрчлийн тухай хуулийн 6.18.4, 6.18.7 дахь хэсэгт заасан зөрчлийн статистик мэдээлэл



Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн Зөрчлийн тухай хуулийн 6.18.4 дэх хэсэгт заасан зөрчлийн тоон мэдээллээс үзвэл нэг талаас энэ төрлийн зөрчлийн тоо буурах хандлагатай байгаа ч нөгөө талаас дэлхий даяар тархсан цар тахлын нөхцөл байдлын улмаас нийслэлд болон орон нутагт тогтоосон хязгаарлалт, хөл хорионы нөхцөл байдал нөлөөлсөн гэж бид үзэж байна.

Харин, биеэ үнэлэхийг зохион байгуулах үйлдлийг 2020 оны 01 дүгээр сард Эрүүгийн хуульд нэмэлтээр оруулж, гэмт хэрэгт тооцсоноос хойш мөн онд 18 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2019 онд бүртгэгдсэн зөрчлийн хэргээс буурсан үзүүлэлттэй байгаа нь нэгдүгээрт цар тахлын нөхцөл байдлын улмаас үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа хязгаарлагдсантай, хоёрдугаарт өмнө нь биеэ үнэлэхийг зохион байгуулах зөрчил гэж зүйлчилдэг байсан үйлдлээ биеэ үнэлэх, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орох зөрчил гэж үзэж, торгох шийтгэл оногдуулж байгаатай холбоотой гэж үзлээ.

#### Шигтгээ 1.

*Биеэ үнэлэхийг зохион байгуулсан байна гэж үзээд хэрэг бүртгэлтийн хэрэг нээх эсхүл эрүүгийн хэрэг үүсгээд яллагдагчаар татах саналаа бариад прокурорт танилцуулахаар наадах чинь зохион байгуулах биш ээ, биеэ үнэлсэн л байна шүү дээ гэх зэргээр хэрэг үүсгэхээс татгалзах тохиолдол надад гарч байсан. Яагаад ийм шийдвэр гаргаад байна вэ гэдгийг би прокурорын ачаалалтай холбоотой гэж харж байгаа...*

Цагдаагийн алба хаагчтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

**Үр дүн 4. Биеэ үнэлэхийг зохион байгуулсан, зуучилсан гэж торгох шийтгэл хүлээсэн хүмүүсийн олонх нь эмэгтэйчүүд бөгөөд тэдний зарим нь энэ төрлийн зөрчлийг хэд хэдэн удаа үйлдэж байсан байна.**

Судалгааны ажлын хүрээнд бид цагдаагийн байгууллагад хадгалагдаж буй 2018-2020 онд шалгаж шийдвэрлэсэн Зөрчлийн тухай хуулийн 6.18.7, 6.18.4 дэх хэсэгт заасан 16 зөрчлийн материалтай танилцлаа.

*Хүснэгт 7. Зөрчлийн хэрэг болон холбогдогчийн тоо*

<b>Зөрчлийн хэрэг</b>	<b>6.18.7. Биеэ үнэлэхийг зохион байгуулах /2020.01.10-нд хүчингүй болсон/</b>			<b>6.18.4. Биеэ үнэлсэн, бусдын биеийг үнэлж бэлгийн харьцаанд орсон</b>		
	<i>Хэрэг</i>	<i>Нийт холбогдогч</i>	<i>Үүнээс эмэгтэй</i>	<i>Хэрэг</i>	<i>Нийт холбогдогч</i>	<i>Үүнээс эмэгтэй</i>
	<b>8</b>	<b>14</b>	<b>14</b>	<b>8</b>	<b>16</b>	<b>15</b>

Дээрх судалгаанаас харахад нийт 30 холбогдогчийн 29 нь буюу 96.7 хувь нь эмэгтэй, нэг нь эрэгтэй хүн байгаа нь анхаарал татаж байна. Тодруулбал биеэ үнэлсэн зөрчил гаргасан 16 эмэгтэйг өөрийнхөө биеэ үнэлэн бэлгийн харьцаанд орсон зөрчил гаргасан гэж шийтгэл оногдуулсан атлаа тэдэнд үнэ төлж бэлгийн харьцаанд орсон зөрчил гаргасан гэж зөвхөн 1 л эрэгтэйд шийтгэл оногдуулсан нь биеэ үнэлсэн хүнд хариуцлага хүлээлгэдэг, тэдний биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон хүнд хариуцлага тооцдоггүй байдал байгааг харуулж байна. Мөн биеэ үнэлэхийг зохион байгуулах зөрчил үйлдэгдсэн бол биеэ үнэлэх, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орох зөрчил зайлшгүй дагалдах учиртай ч зөрчлийн хэргийн материалд 6.18.7, 6.18.4 дэх хэсэгт зааснаар хариуцлага хүлээлгэсэн “ганц” л тохиолдол байна.

*Шигтгээ 2.*

*Баянзүрх дүүргийн прокурорын газраас Баянзүрх дүүргийн Цагдаагийн газрын I хэлтэст /одоогийн нэрээр/ Зөрчлийн тухай хуулийн 6.18.7 /хүчингүй болсон/ дахь хэсэгт заасан зөрчил гаргасан үндэслэлээр зөрчлийн хэрэг нээн шалгасан материалыг хянаж үзээд биеэ үнэлэхийг зохион байгуулсан этгээдэд холбогдох шийтгэл оногдуулсан боловч биеэ үнэлсэн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгээгүй байгааг тодотгон хариуцлага тооцуулахаар материалыг буцааж байжээ.*

*Зөрчлийн хэргийн материалаас...*

Судалгааны багаас танилцсан зөрчлийн 16 хэргийн 30 холбогдогчийн 14 нь өмнө нь Зөрчлийн тухай хуулиар торгуулж байсан өгүүлэмжтэй байна.

Хүснэгт 8. Зөрчилд холбогдсон хүмүүсийн өмнө нь шийтгэгдэж байсан тоо, шийтгэгдсэн зүйл, хэсэг

Холбогдогч	Шийтгэгдсэн зүйл, хэсэг	Өмнө нь шийтгүүлж байсан тохиолдол	Шийтгэгдсэн зүйл, хэсэг
Холбогдогч-1	6.18.7	2	6.18.4
Холбогдогч-2	6.18.7	3	6.18.4
Холбогдогч-3	6.18.4	1	6.18.4
Холбогдогч-4	6.18.4	1	6.18.4
Холбогдогч-5	6.18.4	3	6.18.4
Холбогдогч-6	6.18.4	3	6.18.4
Холбогдогч-7	6.18.4	3	6.18.4
Холбогдогч-8	6.18.7	2	6.18.4
Холбогдогч-9	6.18.7	3	6.18.4
Холбогдогч-10	6.18.7	1	6.18.4
Холбогдогч-11	6.18.7	1	6.18.7
Холбогдогч-12	6.18.4	1	6.18.4
Холбогдогч-13	6.18.4	1	6.18.7
Холбогдогч-14	6.18.4	3	6.18.4

Дээрх мэдээллээс үзвэл Зөрчлийн тухай хуулийн 6.18.7 дахь хэсэгт зааснаар шийтгэл хүлээсэн 7 хүний 6 нь өмнө нь мөн хуулийн 6.18.4 буюу биеэ үнэлсэн гэж 1-3 удаа шийтгүүлсэн бол 1 нь биеэ үнэлэхийг зохион байгуулах зөрчлийг давтан үйлджээ. Эндээс ажиглагдаж буй нэг зүйл нь өмнө нь биеэ үнэлдэг байсан эмэгтэйчүүд хэсэг хугацааны дараа биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт үйлдлийг гаргаж байгааг холбогдох байгууллагууд анхааралдаа авах зайлшгүй шаардлагатай байна.

Зураг 7. Зөрчлийн тухай хуулиар шийтгэл хүлээсэн эмэгтэй холбогдогч нарын насны бүтэц



Насны бүтцээс авч үзвэл 20-24 насны эмэгтэйчүүд биеэ үнэлэх болон биеэ үнэлэхийг зохион байгуулах явдал харьцангуй бага байгаа бол 30-35 насны эмэгтэйчүүд биеэ үнэлэх, биеэ үнэлэхийг зохион байгуулах явдал их байгаа нь харагдаж байна.

**Үр дүн 5. Биеэ үнэлэх, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орох /биеэ үнэлэхийг зохион байгуулах/ зөрчлийг хялбаршуулсан журмаар шалгаж, шийдвэрлэх явдал түгээмэл байна.**

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль<sup>12</sup> /цаашид ЗШШТХ гэх/-ийн 6.6 дугаар зүйлд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг дараах үндэслэл тогтоогдвол хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжийг бий болгосон байна. Үүнд:

1. Зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой, зөрчил, учирсан хохирлыг нотлох талаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй бол;
2. Зөрчил үйлдэгдсэн, учруулсан хохирол нь нотлох баримтаар тогтоогдож холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн бол;
3. Зөрчил үйлдсэн болох нь стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмжөөр нотлогдсон бол.

Судалгааны баг танилцах боломжтой 16 зөрчлийн хэргийн материалтай<sup>13</sup> нэг бүрчлэн танилцсан бөгөөд тэдгээрийг зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой, зөрчил үйлдэгдсэн, учруулсан хохирол нь нотлох баримтаар тогтоогдож холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн үндэслэлээр хялбаршуулсан журмаар 1-3 хоногт багтаан шийдвэрлэсэн байсан.

Аливаа гэмт хэрэг, зөрчлийг хуулийн боломжит хугацаанд, оролцогч талуудын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндөхгүйгээр шийдвэрлэх, гэмт хэрэг, зөрчил гаргасан этгээдэд хуулийн тохирох хариуцлага хүлээлгэх нь зүйд нийцнэ. Гэхдээ бүх зөрчлийг, ялангуяа биеэ үнэлэх, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орох зөрчил бүрийг хялбаршуулсан байдлаар шийдвэрлэх нь цаанаа хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг нуун далдлах нөхцөл байдал үүсгэж болзошгүйг хууль сахиулах байгууллага анхаарах шаардлагатай байна. Түүнчлэн хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны цаана зөрчил гаргасан эсэх нь баримтаар тогтоогдоогүй байхад нь хариуцлага хүлээлгэсэн байж болзошгүй хэд хэдэн мэдүүлгэн нотлох баримтууд зөрчлийн хэргийн материалд авагдсан байна.

Зөрчлийг шалгах ажиллагааны хүрээнд зөрчил үйлдсэн этгээдүүдээс тайлбар, мэдүүлэг авч байгаа боловч гаргасан үйлдэл нь хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шинжтэй байж болох эсэх талаар нарийвчлан асууж тодруулсан зүйлгүй байгаа нь анхаарал татаж байв.

---

<sup>12</sup> Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №24

<sup>13</sup> Зөрчлийн хэргийн материалд гомдол, мэдээллийг хүлээн авах, холбогдогч болон бусад гэрчүүдээс авсан мэдүүлэг, баталгааны хуудас болон гэрэл зургийн үзүүлэлт, холбогдогч нарын өмнө нь шийтгэгдсэн байдлын тодорхойлолт зэрэг материал байна.

*Шигтгээ 3.*

*Би энэ массажны газар ажилладаг ба манайд ямар ч үйлчлүүлэгч байгаагүй. Манай найз Б, түүнийг авах гэж ирсэн Э нарыг байхад цагдаа нар орж ирсэн. Биеэ үнэлж байгаагүй, торгуулахад татгалзах зүйлгүй.*

*Зөрчлийн хэргийн материалаас...*

*Шигтгээ 4.*

*Гэрийнхэнтэйгээ маргалдаад найзынхаа саун дээр ирээд унтаж байхад цагдаа нар ирсэн. Би биеэ үнэлж байгаагүй, торгуулахад татгалзах зүйл байхгүй*

*Зөрчлийн хэргийн материалаас...*

*Шигтгээ 5.*

*Би уг массажны газар бие угаагчаар ажилладаг ба өнөөдөр бусадтай бэлгийн харьцаанд ороогүй. Харин өмнө нь хэд хэдэн удаа мөнгөөр бэлгийн харьцаанд орж байсан.*

*Зөрчлийн хэргийн материалаас...*

Дээрх 3 тохиолдолд бүгдэд нь Зөрчлийн тухай хуулийн 6.18.4 дэх хэсэгт зааснаар<sup>14</sup> 50.000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан нь анхаарал татаж байна. Эдгээр холбогдогч нар нь өмнө тус бүр 1 удаа биеэ үнэлсэн гэж мөн торгуулж байсан нь зөрчлийн хэргийн материал дахь цахим сангийн мэдээллээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл тухайн нөхцөл байдалд биеэ үнэлж байгаагүй гэдгээ мэдүүлсэн ч эдгээр зөрчил гаргасан хүмүүс бүгд зөрчил гаргасан гэдгээ хүлээн зөвшөөрч, зөрчлийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх санал гаргасан, хяналт тавьж буй прокурорууд зөрчил шалгаж шийдвэрлэх ажиллагааг энгийн журмаар явуулж, зөрчлийн шинж байдлыг тогтоох талаар буцаасан 1 ч тохиолдол байхгүй нь анхаарал татаж байна.

Өөрөөр хэлбэл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан прокуророос зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих хяналтын чиг үүргээ, мөн хуулийн 2.3 дугаар зүйлд зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан хүлээлгэсэн бүрэн эрхийг, мөн хуулийн 2.4 дүгээр зүйлд зааснаар зөрчлийн хэрэг бүртгэгч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэгжүүлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй байх, хайнга хандах явдал байгаа нь ажиглагдаж байна.


Судалгааны багаас биеэ үнэлэх, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орох зөрчлийг өөгшүүлэн зөвтгөөгүй ч хууль ёсны байх, гэмт хэрэг, зөрчлийн бодит байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоох зарчим алдагдаж байгааг энд гаргаж ирэхийг зорьсон болно.

<sup>14</sup> Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №24, 6 дугаар бүлэг, 6.18 дугаар зүйлийн 6.18.4. Биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, эсхүл бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно

## 2.2. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид ЭХХШТХ/-д зааснаар аливаа гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж, шийдвэрлэх ажиллагаа дараах процессын дагуу явагдаж байна.

Зураг 8. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, шийдвэрлэх ажиллагааны процессын зураглал




Хүн, хуулийн этгээдээс энэ төрлийн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгуулахаар хүсэлт гаргаж, гаргасан хүсэлтийг нь хүлээн авах болон хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан тохиолдолд гомдол гаргагч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.1 дүгээр зүйлд “Эрүүгийн

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах тухай хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргах эрхтэй”, 15.7 дугаар зүйлд оролцогч нь мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гаргах гомдлыг хяналт тавьж байгаа прокурорт, хяналт тавьж байгаа прокурорын шийдвэр, ажиллагааны талаарх гомдлыг тухайн нэгжийн дээд шатны прокурорт шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор гаргана гэж заасны дагуу гомдлоо гаргаж, шийдвэрлүүлэх эрхтэй байна.

Мөн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулахаар шийдвэрлэсэн хэргийн процессын зураглалыг дор үзүүлбэл:

Зураг 9. Хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах, шийдвэрлэх үеийн процессын зураглал





**Үр дүн 6. Цагдаагийн байгууллагын бүтцэд ХХГХ болон Хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг мөрдөх бие даасан нэгж байгуулагдсан нь сайшаалтай байна.**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор баталсан “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр” /цаашид Үндэсний хөтөлбөр гэх/-ийн хүрээнд ЦЕГ-ын даргын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн тушаалаар Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийг ЭЦА-ны зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн бүтцэд 5 хүний орон тоотой байгуулсан. Уг хэлтэс нь Улсын Ерөнхий Прокурорын 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/33 дугаар “Гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харьяаллыг шинэчлэн тогтоох тухай” тушаалаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйл Бэлгийн мөлжлөг, 13 дугаар бүлгийн 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах, 15.3 дугаар зүйл Хүний цус, эд эрхтэнг хууль бусаар авах, 15.4 дүгээр зүйл Хүний цус, эд, эрхтэнийг шаардлага хангаагүй нөхцөлд бэлтгэх, шилжүүлэн суулгах, 16.8 дугаар зүйл Хүүхэд садар самууныг сурталчлах, уруу татах, 16.9 дүгээр зүйл Хүүхэд оролцуулж садар самуун сурталчлах гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, гэмт хэргийг шалгах харьяаллыг тогтоосон.

Мөн ЦЕГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/316 дугаар тушаалаар Мөрдөн байцаах албаны бүтцэд Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтсийг шинээр байгуулан ажиллаж байна. Тус хэлтэс нь Монгол Улсын Ерөнхий прокурорын 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/33 дугаар Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харьяаллыг шинэчлэн тогтоох тухай тушаал болон 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/32 дугаар Тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай тушаалын хавсралтад зааснаар Эрүүгийн хуулийн 16.2 дугаар зүйл Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах, 16.3 дугаар зүйл Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх, 16.4 дүгээр зүйл Хүүхдээр гуйлга гуйлгах, 16.5 дугаар зүйл Хүүхэд солих, 16.6 дугаар зүйл Хүүхэд худалдах, 16.7 дугаар зүйл Хүүхэдтэй хэрцгий харьцах, 16.9 дүгээр зүйл Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах гэмт хэргийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад зааснаас бусад хэрэгт, 16.10 дугаар зүйл Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, 16.11 дүгээр зүйл Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх гэмт хэргийг харьяалуулан шалгаж байна.

Хэдийгээр цагдаагийн байгууллагын эрүүгийн болон Мөрдөн байцаах албаны бүтцэд ХХГХ болон хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэргийг мөрдөх нэгж байгуулагдсан хэдий ч энэ төрлийн гэмт хэргийн анхны дуудлага, гомдол, мэдээлэл нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад дийлэнхдээ бүртгэгдэж, хойшлуулшгүй ажиллагаа явуулаад Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт бүлэг, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Мөрдөн байцаах албаны Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэст харьяаллын дагуу шилжүүлдэг байна.

Шигтгээ 6.

Цагдаагийн байгууллагын алба хаагчдын хувьд ХХГХ болон түүнтэй төстэй эрүүгийн хэргийн талаарх мэдлэг мэргэшсэн төв байгууллагын мөрдөгчдөөс бусад нэгжүүдийн мөрдөгч болон алба хаагчдын мэдлэг хангалтгүй. Яагаад гэхээр энэ төрлийн гэмт хэргийн гаралт харьцангуй бага учраас алба хаагчдын мэдлэг мэдээлэл ойлголт бага байгаа байх

Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

Шигтгээ 7.

Дүүргийн цагдаагийн хэлтэст ажиллаж байсны хувьд хэлэхэд ХХГХ болон хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийн талаарх ойлголт муу шүү дээ. Тэгэхээр сургалт, сурталчилгааны ажил хийх л хэрэгтэй гэж бодож байна.

Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

Шигтгээ 8.

Монгол улсын прокурорын байгууллагын хувьд Хүн худалдаалах эрүүгийн хэрэг, гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэлд Нийслэлийн прокурорын газраас хяналт тавьж ажилладаг нийт прокуроруудын хувьд хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдлэг, ойлголт хангалттай түвшинд байгаа гэж ойлгоход хэцүү гэж бодож байна. Харин ижил төстэй биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт бүх прокурорын газрууд хяналт тавьж ажилладаг тул тус хэргийн талаар ойлголт мэдлэг хангалттай байгаа гэж үзэж байна.

Прокурортой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

Шигтгээ 9.

Иргэн Б 2018 оны 06 сард “миний 12 настай охиныг нэгэн фэйсбүүк хэрэглэгч садар самуунд уруу татсан байна” гэх гомдлыг нэгэн дүүргийн цагдаагийн хэлтэст гаргасан боловч тухайн асуудлыг зөрчлийн бүртгэлд авч, хэсгийн байцаагч шалган зөрчлийн шинжгүй гэх үндэслэлээр зөрчлийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлж, прокурор энэ үндэслэлээр татгалзаж шийдвэрлэсэн байна.

Гэвч гомдол гаргагч энэ шийдвэрт дээд шатны прокурорт нь гомдол гаргаснаар уг асуудлыг Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт бүлэг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн мөрдөгч шалгаж, Эрүүгийн хуулийн 16.8 дугаар зүйлд заасан Хүүхдэд садар самууныг сурталчлах гэмт хэрэг гэж үзэн холбогдох мөрдөн шалгах ажиллагааг явуулсан бөгөөд хэргийг анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцээд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн бөгөөд зүйлчлэлийг өөрчлөөгүй байна.

Эрүүгийн 180...755 дугаартай хэргийн материалаас

Аливаа гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, шалгах ажиллагааг оновчтой зөв явуулж, анхны мэдээллийг баталгаажуулах нь цаашид тухайн гэмт хэргийг зөв зүйлчлэх, гэмт хэрэгт өртөж хохирсон хүний

хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг зөв тогтоож, түүнд ял шийтгэл оногдуулахад чухал ач холбогдолтой байдаг.

**Үр дүн 7. ХХГХ болон түүнтэй төстэй гэмт хэрэг, ялангуяа хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд оруулах замаар гэмт хэргийн хохирогч болгох явдал тогтвортойгоор өсөх хандлагатай байна.**

Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистикийн мэдээллээс үзвэл 2018-2021 оны байдлаар бүртгэгдсэн хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн тоон судалгааг авч үзвэл:

Зураг 10. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



Ялангуяа хүүхдэд садар самууныг сурталчлах, түүнд татан оруулах замаар бэлгийн хүчирхийллийн хохирогч болгох, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх явдал сүүлийн 4 жилийн хугацаанд өссөн дүнтэй байгаа нь дээрх судалгаанаас ажиглагдаж байна. Мөн хүн худалдаалах гэмт хэргийн гаралт жил тутам өсөх хандлага ажиглагдаж байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд дэлхий нийтээр тархсан цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор улсын хилээс гадна дотоодын зорчих хөдөлгөөнийг хязгаарласан нь 2021 онд хүн худалдаалах 8 гэмт хэрэг бүртгэгдэхэд нөлөөлсөн гэж үзэж болох ч энэ нь гэмт хэргийн гаралт багасаж байна гэж үзэхээс илүүтэй нууц далд хэлбэрт шилжиж байж болзошгүй гэж үзэх нөхцөлийг бий болгож байна.

Зураг 11. 2020, 2021 онд бүртгэгдсэн зарим гэмт хэрэг хохирогчоор тогтоогдсон насанд хүрээгүй хүний тоон харьцуулалт



Прокурорын байгууллагаас ирүүлсэн мэдээллээр 2021 онд бүртгэгдсэн хүн худалдаалах 8 гэмт хэрэгт 10, бэлгийн мөлжлөгийн 3 гэмт хэрэгт 2, биеэ үнэлэхийг зохион байгуулах 9 гэмт хэрэгт 1, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах 19 гэмт хэрэгт 16, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах 2 гэмт хэрэгт 6 насанд хүрээгүй хүн хохирогчоор тогтоогдсон гэжээ. Гэтэл 2020 онд эдгээр гэмт хэрэгт 17 насанд хүрээгүй хүн хохирогчоор тогтоогдож байсан бөгөөд 2021 онд энэ тоо 1 дахин өссөн үзүүлэлттэй байгаа нь анхаарал татаж байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль дахь нэг ололттой тал нь академик<sup>15</sup> тайлбарыг хуульд шууд зааж өгсөн явдал юм. Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлд заасан биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг үйлдэхдээ арван найман насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн бол хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарна гэж тайлбарласан. Гэтэл прокурорын байгууллагаас авсан тоон мэдээлэлд энэ гэмт хэрэгт насанд хүрээгүй 1 хүн хохирогчоор тогтоогдсон талаар мэдээллэсэн байна.

Өөрөөр хэлбэл насанд хүрээгүй хүний эсрэг биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг үйлдсэн гэдгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих, мөрдөх эрх бүхий байгууллага мэдсэн боловч хүн худалдаалах гэмт хэрэгт тооцож шийдвэрлээгүй явдал нь Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй алдаа байсаар байгааг харуулж байна.

**Үр дүн 8. Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж байгаа ч гомдол, мэдээллийг шалгах ажиллагааны төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.**

ЭХХШТХ-ийн 30 дугаар бүлэгт гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, шийдвэрлэх талаар заасан бөгөөд хуулийн энэ зохицуулалтын дагуу мөрдөгч, прокурор өөрсдийн чиг үүргийн дагуу

<sup>15</sup> Хуульд зарим ойлголтыг шууд тайлбарлан заасныг ойлгоно.

ажиллаж байна. Мөрдөгч, прокуророос аливаа гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш тухайн гомдол, мэдээлэлд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтоох зорилгоор ЭХХШтХ-ийн 30.7 дугаар зүйлийн 1.1-1.6 дах хэсэгт зааснаар гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах ажиллагааг 5 хоногт багтаан явуулдаг. Шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга нь дээрх хугацааг 14 хүртэл хоногоор сунгадаг.

Цагдаагийн алба хаагчидтай хийсэн ярилцлагын үр дүнгээс үзвэл хүн худалдаалах болон түүнтэй төстэй бусад гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа бөгөөд хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах ажиллагааны өмнө мөрдөгч, прокурор харилцан ойлголцож, холбогдох нотлох баримтад тулгуурлан зүйлчлэлээ тодорхой болгодог нь харагдаж байна.

Мөн ярилцлагад оролцсон 14 прокурорын 9 нь энэ төрлийн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан тохиолдол байхгүй гэж хариулжээ.

Прокурорын байгууллагаас авсан мэдээлээр 2018-2021 онд хүн худалдаалах 73 гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 43 хэргийг хэрэг бүртгэлтийн хэргийг ЭХХШтХ-ийн 30.10 дугаар зүйлд заасан үндэслэлээр хаасан гэжээ. Өөрөөр хэлбэл энэ төрлийн гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзсан тохиолдол байхгүй бөгөөд хүлээн авч, шалгах ажиллагаа явуулсны дараа тодорхой шийдвэрүүдийг гаргасан байна.

#### *Шигтгээ 10.*

*ХХГХ болон түүнтэй төстэй хэргийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах тохиолдол байхгүй. Цагдаагийн байгууллага нь иргэдээс ирүүлсэн гомдол мэдээлэл тус бүрийг харьяалал харгалзахгүй авдаг бөгөөд түүнийг хүлээн авсан мөрдөгч, гэмт хэргийн шинжтэй эсэхийг харгалзан үзэж байж шийдвэр гаргадаг бөгөөд үүнд прокуророос хяналт тавьж ажилладаг.*

*Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

#### *Шигтгээ 11.*

*Ихэнх тохиолдолд гэмт хэрэг үйлдэгдсэн болох нь тогтоогдоогүй буюу гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр шийдэгддэг. Учир нь энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж байгаа хүмүүс нарийн зохион байгуулалттай ажилладаг бөгөөд урд өөрсдөө энэ төрлийн гэмт хэрэгт ямар нэг байдлаар өртөж байсан, гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх талаар мэдлэг мэдээлэлтэй хүмүүс үйлддэг тул тэдний үйлдсэн гэмт хэргийг нотлох асуудал хүндрэлтэй байдаг.*

*Прокурортой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

Судалгаанд нийт 14 шүүгч оролцсоноос 9 нь буюу 64.2 хувь нь энэ төрлийн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна. Тодруулбал мөрдөгч, прокурорын энэ төрлийн гэмт хэргийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх замаар гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч шалгахдаа хохирсон байж болзошгүй хүний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг эн тэргүүнд тавьж, боломжит бүхий л ажиллагааг явуулах нь чухал байгааг онцолжээ.

ЭХХШТХ-ийн 6.1 дүгээр зүйлд мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагуудын талаар заасан бөгөөд мөн зүйлийн 1.2 дахь заалтад тагнуулын байгууллага өөрсдөө илрүүлсэн Эрүүгийн хуулийн 13.1 Хүн худалдаалах гэмт хэрэгт, мөн зүйлийн 6.1.3 дахь хэсэгт Цагдаагийн байгууллага энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна гэж заасан нь хүн худалдаалах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шалгах эрх бүхий 2 байгууллага байгааг харуулж байна.

Мөрдөгч гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хянан үзээд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтоох шаардлагатай бол гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор дараах мөрдөн шалгах ажиллагаа явуулна. Үүнд:

- үзлэг хийх;
- шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах;
- хохирогч, гэрчээс мэдүүлэг авах;
- хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хурааж авах;
- эд хөрөнгийг битүүмжлэх.
- шинжээч томилох зэрэг болно.

Дээрх ажиллагааг явуулснаар мөрдөгч хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг прокурорт гаргах, харьяаллын дагуу шилжүүлэх саналыг прокурорт гаргах гэсэн шийдвэрүүдийн аль нэгийг гаргах учиртай.

Гэхдээ гомдол, мэдээллийг шалгах ажиллагааны цар хүрээ, явуулах боломжит процессын ажиллагаанаас хамаараад хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, шийдвэрлэх тохиолдол байна. Өөрөөр хэлбэл ЭХХШТХ-ийн 30.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн нь энэ хуульд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл болно” гэж заасан нь дээр дурдсан 6 төрлийн ажиллагаанаас бусад мөрдөн шалгах тодорхой ажиллагааг гомдол, мэдээллийг шалгах ажиллагааны хүрээнд явуулах боломжийг хязгаарлаж улмаар зарим тохиолдолд гэмт хэргийн шинжийг тогтоох боломжгүйд хүрч байгааг анхаарах учиртай.

Шигтгээ 12.

Монгол Улсын иргэн Б.Э-г Б.Б нь хууран мэхлэх замаар Испани улсад аваачин хүчээр хөдөлмөр эрхлүүлж, биеийг нь үнэлүүлэн, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэх гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг ТЕГ-аас хүлээн авч шалгаад хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан байна. Нийслэлийн прокурорын газрын 2021 оны 1/1983 дугаартай хариу мэдэгдэх хуудаст “таны гомдолдоо хавсаргаж өгсөн Испанийн цагдаагийн байгууллагаас ирүүлсэн гэх материалд иргэн Б.Э-ийн өгсөн мэдээллийн дагуу Испанийн цагдаагийн газрын Цагаачлал, хилийн цагдаагийн ерөнхий газрын Хууль бус цагаачлал болон мөнгө угаалт, зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээтэй тэмцэх байгууллагаас Г.Э, Ш.О, Б.Б нарын тухай тодруулах ажиллагаа хийгдэн шалгагдаж байна талаар дурдаж хамтран ажиллахыг санал болгосон байна. Энэ нь Испани улсад тухайн асуудлыг шалгаж байгаа талаарх мэдээлэл бөгөөд нотлох баримт бүхий хэрэг материал ирүүлсэн тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шалгах эсэх асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж үзэв” гэжээ.

Нийслэлийн прокурорын газрын 2021.07.06-ны өдрийн 246 дугаартай Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах тухай тогтоолоос

**Үр дүн 9. ХХГХ, түүнтэй төстэй гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгаад, хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах ажиллагаанд Эрүүгийн хуульд ХХГХ-ийн хэлбэр бүрийг тусгайлан бие даасан гэмт хэрэг болгож зохицуулсан нь сөргөөр нөлөөлөх хандлагатай байна.**

Монгол Улсын 2008 онд нэгдэн орсон Палермогийн протоколд “ХХГХ гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ.”

Дээрх аргуудын аль нэгийг ашигласан тохиолдолд хохирогч өөрийг нь дээр дурдсан аргаар мөлжих гэж байгааг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхээр заасан. Мөлжих зорилгоор хүүхдийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авсан аливаа үйлдэл нь дээр дурдсан аргаар үйлдсэн байхыг шаардахгүйгээр ХХГХ-т тооцно” гэжээ.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд мөн ХХГХ-ийг хуульчлахдаа бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих, эд эрхтэнийг авах зэрэг үйлдлийг ХХГХ-т тооцох, хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход ямар аргаар үйлдсэн байх нь хамааралгүй байхаар зохицуулсан. Гэвч Эрүүгийн хуульд ХХГХ-ийн хэлбэр бүрийг тусгайлан бие даасан гэмт хэрэг болгож зохицуулсан нь хуулийн зүйл, заалтын давхардал үүсгэж, энэ нь хуулийн заалтыг нэг мөр ойлгож хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд эргэлзээтэй, тодорхойгүй байдал үүсгэж буй байдал ажиглагдсан. Үүнд:

Хүснэгт 9. Хүн худалдаалах болон Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн харьцуулалт

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах	Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйл Бэлгийн мөлжлөг
Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, ... мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг Хүн худалдаалах гэмт хэрэг гэнэ.	Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан үйлдлийг Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг гэнэ.
<b>Зорилго</b>	
Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, ... мөлжих зорилгоор	
<b>Үйлдлийн арга</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• хүч хэрэглэх</li> <li>• хүч хэрэглэхээр заналхийлэх</li> <li>• хулгайлах</li> <li>• хууран мэхлэх</li> <li>• итгэл эвдэх</li> <li>• эрх мэдлээ урвуулах</li> <li>• эмзэг байдлыг нь далимдуулах</li> <li>• хяналтдаа байлгаж байгаа хүнд нь төлбөр төлж, хахуульдах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• хүч хэрэглэх</li> <li>• хүч хэрэглэхээр заналхийлэх</li> <li>• эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулах</li> </ul>
<b>Үйлдэл</b>	
Элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах	Бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулах
<p>Хэдийгээр Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн үндсэн бүрэлдэхүүнд Хүн худалдаалах гэмт хэргээс ялгах шинжийг “зорчих эрхийг хязгаарлахгүйгээр” гэж томъёолсон боловч 12.3.2, 12.3.4 дэх хэсэгт <b>хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор</b> гэж заасан нь өрсөлдүүлсэн хэм хэмжээ болж, мөрдөгч, прокурор, шүүхээс мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төвөгтэй байдал бий болгож байна.</p> <p>Мөн хуулийн 13.1 дүгээр зүйлийн тайлбарт “Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход ямар аргаар үйлдсэн байхыг шаардахгүй” гэсэн боловч хүүхдийн эсрэг үйлдэж байгаа бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг гэж байхаар зохицуулсан байгааг анхаарах хэрэгтэй байна.</p>	



*Хүснэгт 10. Хүн худалдаалах болон албадан хөдөлмөрлүүлэх  
гэмт хэргийн харьцуулалт*

<b>Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах</b>	<b>Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйл Албадан хөдөлмөрлүүлэх</b>
<p>... боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтэнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг Хүн худалдаалах гэмт хэрэг гэнэ.</p>	<p>Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн үйлдлийг Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг гэнэ.</p>
<b>Зорилго</b>	
<p>боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтэнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор</p>	
<b>Үйлдлийн арга</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• хүч хэрэглэх</li> <li>• хүч хэрэглэхээр заналхийлэх</li> <li>• хулгайлах</li> <li>• хууран мэхлэх</li> <li>• итгэл эвдэх</li> <li>• эрх мэдлээ урвуулах</li> <li>• эмзэг байдлыг нь далимдуулах</li> <li>• хяналтдаа байлгаж байгаа хүнд нь төлбөр төлж, хахуульдах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• хүч хэрэглэх</li> <li>• хүч хэрэглэхээр заналхийлэх</li> <li>• илт хохиролтой болзол, нөхцөл тулгах</li> <li>• хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулах</li> <li>• эрхшээлдээ оруулах</li> </ul>
<b>Үйлдэл</b>	
<p>Элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах</p>	<p>Цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлэх</p>
<p>Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлд албадан хөдөлмөрлүүлэх явдлыг гэмт хэрэгт тооцохоор заасан. Гэвч тус заалтын зүйлчлэлийн агуулга нь Эрүүгийн хуулийн 13.1 ХХГХ-т заасан хүн худалдаалах гэмт хэргийн албадан хөдөлмөрлүүлж мөлжих үйлдлийн шинжтэй давхцаж байна.</p>	

*Хүснэгт 11. Хүн худалдаалах болон Хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах гэмт хэргийн харьцуулалт*

<b>Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах</b>	<b>Эрүүгийн хуулийн 15.3 дугаар зүйл Хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах</b>
<p>... эд, эрхтэнийг авах, ... мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг Хүн худалдаалах гэмт хэрэг гэнэ.</p>	<p>Хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж хүний цус, эс, эд, эрхтэнийг авсан үйлдлийг Хүний цус, эс, эд эрхтэнийг хууль бусаар авах гэмт хэрэг гэнэ.</p>
<b>Зорилго</b>	
эд, эрхтэнийг авах, ... мөлжих зорилгоор	
<b>Үйлдлийн арга</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• хүч хэрэглэх</li> <li>• хүч хэрэглэхээр заналхийлэх</li> <li>• хулгайлах</li> <li>• хууран мэхлэх</li> <li>• итгэл эвдэх</li> <li>• эрх мэдлээ урвуулах</li> <li>• эмзэг байдлыг нь далимдуулах</li> <li>• хяналтдаа байлгаж байгаа хүнд нь төлбөр төлж, хахуульдах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• хуурч мэхлэх</li> <li>• хүч хэрэглэх</li> <li>• хүч хэрэглэхээр заналхийлэх</li> </ul>
<b>Үйлдэл</b>	
Элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах	Хүний цус, эс, эд, эрхтэнийг авах
<p>Эрүүгийн хуулийн 15.3 дугаар зүйлд Хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах гэмт хэргийг заахдаа “хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдал, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж хүний цусыг, эсийг, эд, эрхтэнийг авсан” бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан боловч энэ нь ХХГХ-ийн “... хүний эд, эрхтэнийг авах...” үйлдлийг мөн хамарсан байна.</p>	

**ХҮН ХУДАЛДААЛАХ, ТҮҮНТЭЙ ТӨСТЭЙ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ  
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

*Хүснэгт 12. Хүн худалдаалах болон хүүхдийн эсрэг үйлдэж буй энэ төрлийн гэмт хэргийн харьцуулалт*

Эрүүгийн хуулийн 16.4 дүгээр зүйл Хүүхдээр гуйлга гуйлгах	Эрүүгийн хуулийн 16.6 дугаар зүйл Хүүхэд худалдах	Эрүүгийн хуулийн 16.8 дугаар зүйл Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах	Эрүүгийн хуулийн 16.9 дүгээр зүйл Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах	Эрүүгийн хуулийн 16.10 дугаар зүйл Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх
Хүүхдэд амлалт өгч, хууран мэхэлж; хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулж байнга гуйлга гуйлгасан үйлдлийг Хүүхдээр гуйлга гуйлгах гэмт хэрэг гэнэ.	Төрүүлсэн, үрчлэн авсан, асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа хүүхдээ бусдад худалдсан үйлдлийг Хүүхэд худалдах гэмт хэрэг гэнэ.	Хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон үйлдлийг Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэг гэнэ.	Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан үйлдлийг Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах гэмт хэрэг гэнэ.	Хүүхдээр аюултай ажил, эрүүл мэнд, бие бялдар, оюун санаанд нь хохирол учруулахуйц хориглосон ажил, үйлчилгээ зориуд эрхлүүлсэн үйлдлийг Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэг гэнэ.
<b>Үйлдлийн арга</b>				
<ul style="list-style-type: none"> <li>• хүүхдэд амлалт өгөх</li> <li>• хүч хэрэглэх</li> <li>• хүч хэрэглэхээр заналхийлэх</li> <li>• хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулах</li> </ul>	•	•	• цахим сүлжээ ашиглах	•
<b>Үйлдэл</b>				
Байнга гуйлга гуйлгасан	Бусдад худалдах	зориуд үзүүлэх, өгөх, сурталчлах, хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэх, хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгох	Бэлтгэх, борлуулах, тараах, хадгалах	хориглосон ажил, үйлчилгээ зориуд эрхлүүлэх

1. Монгол Улс 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц болон түүний нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд хүн ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба шийтгэх талаар онцгойлон авч үзсэнээрээ онцлог ба ХХГХ-ийн гол объект болох эмэгтэйчүүд, хүүхдийн эрх ашгийг тусгайлан хамгаалсан чиг үүрэгтэй олон улсын эрх зүйн гол баримт бичиг болж байна. Уг протоколд насанд хүрээгүй хүний эсрэг энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхэд гэмт хэргийг ямар аргаар үйлдсэнийг хамаарахгүй гэдгийг онцолсон байдаг.
2. Хүүхдээр гуйлга гуйлгах, хүүхдийг худалдах, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт үйлдлийг хуульчлахдаа гэмт хэргийн субъектив талын шинж болох гэмт хэргийн зорилгыг тодорхой заагаагүй ч эдгээр үйлдлийг хийлгэх нь гэмт хэрэг үйлдэгдэгчид тодорхой ашигтай байх нь тодорхой харагдаж байгаа юм. Мөн хүүхдэд садар самууныг сурталчлах, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан үйлдэл нь бэлгийн мөлжлөгийн бусад хэлбэрт хамаарна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар тогтоолд хүн худалдаалах гэмт хэргийн шинжүүдийг дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд.
  - “Хүн худалдаалах” гэдэгт тодорхой төлбөртэйгөөр (**мөнгө авах, эд хөрөнгө болон түүнийг өмчлөх эрхээр солилцох** г.м) эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож (өрөнд өгөх г.м) хүнийг бусад хүмүүсийн мэдэлд бүр мөсөн буюу тодорхой хугацаагаар шилжүүлэхийг ойлгоно.
  - “Ашиг олох зорилгоор” гэж хүн худалдаалах замаар **өөртөө болон бусад этгээдэд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус ашигтай байдал, орлого** бий болгохыг хэлнэ.
  - “Бэлгийн хүчирхийлэлд оруулах” гэдэгт биеийг нь үнэлүүлэхээс гадна тулган шаардах, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж **садар самууныг сурталчлахад татаж оруулсан**, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан аливаа үйлдэл хийсэн зэргийг ойлгоно гэжээ.
3. Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт **Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход ямар аргаар үйлдсэн байхыг шаардахгүй** гэсэн байна.

Ийнхүү ХХГХ-ийн төрөл хэлбэр тус бүрийг бие даасан гэмт хэрэг гэж тооцох нь энэ төрлийн гэмт хэргийг бусад гэмт хэргээр зүйлчилж, эрх зүйн байдлыг дээрдүүлж байна гэх үндэслэлээр<sup>16</sup> гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завшуулах нөхцөлийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, хэрэг хянан шийдвэрлэх явцад нийтлэг тохиолдолд гэмт хэрэг үйлдэгчийн субъектив санаа, сэдлийг тодорхойлох боломжгүй нөхцөлд түүний эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийн заалтаар буюу бага ялтай зүйл ангиар шийдвэрлэх зарчим үйлчилдэг.

*Шигтгээ 13.*

*ХХГХ-ээр зүйлчлээд яллах дүгнэлт үйлдээд шүүхэд ирүүлсэн хэргийг шүүх бэлгийн мөлжлөгөөр зүйлчилж зүйлчлэл нэлээд түгээмэл. Энэ нь эргэлзээтэй бол шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зарчимтай уялдаж байгаа. Хэрэв бэлгийн мөлжлөг гэж тусад нь заахгүйгээр ХХГХ-ийг заасан байсан бол ХХГХ-ээр шийдвэрлэгдэх байсан. ХХГХ-ийн ялаас бэлгийн мөлжлөгийн ял хөнгөн буюу хорих ялын хэмжээ бага байдаг.*

*Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

<sup>16</sup> Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2015, №7, 1.15 дугаар зүйл. Гэм буруугүйд тооцох. Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, яланд ашигтайгаар шийдвэрлэнэ.

*Шигтгээ 14.*

*Хүн худалдаалахын эсрэг конвенцтой холбогдуулан Эрүүгийн хуульд тараан байршуулан заасан олон зүйл заалтыг нэг, ойлгомжтой байдлаар заалт болгох хэрэгтэй. Ялангуяа, ХХГХ- бэлгийн мөлжлөг.*

*Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

*Хүснэгт 13. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зарим гэмт хэрэгт оногдуулахаар заасан эрүүгийн хариуцлагын харьцуулалт*

<b>Хэсэг Зүйл</b>	<b>1 дэх хэсэг</b>	<b>2 дахь хэсэг</b>	<b>3 дахь хэсэг</b>	<b>4 дэх хэсэг</b>
13.1. Хүн худалдаалах	2-8 жил хүртэл хугацаагаар хорих	5-12 жил хүртэл хугацаагаар хорих	12-20 жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих	
12.3 Бэлгийн мөлжлөг	1-5 жил хүртэл хугацаагаар хорих	2-8 жил хүртэл хугацаагаар хорих	5-12 жил хүртэл хугацаагаар хорих	12-20 жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял
12.6. Биеэ үнэлэхийг зохион байгуулах	6 сараас 3 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих	1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих	5-12 жил хүртэл хугацаагаар хорих	
13.13. Албадан хөдөлмөрлүүлэх	торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих			
15.3. Хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах	1-5 жил хүртэл хугацаагаар хорих	2-8 жил хүртэл хугацаагаар хорих	5-12 жил хүртэл хугацаагаар хорих	
16.4. Хүүхдээр гуйлга гуйлгах	нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих			

16.6. Хүүхэд худалдах	торгох, эсхүл 2-8 жил хүртэл хугацаагаар хорих			
16.8. Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах	торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих			
16.9. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах	торгох, зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих	торгох, эсхүл 2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял		
16.10. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх	торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих			

Энэ төрлийн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах ажиллагааны явцад хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох боломж хязгаарлагдмал тул аль болох хүнд ялтай зүйл хэсгээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгах талаар мөрдөгч, прокурор аль аль анхаарах нь зүйн хэрэг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчдээс өгсөн мэдээллийг энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон иргэдээс тодруулах зорилгоор судалгаа авч үзэхэд хэргийн зүйлчлэл өөрчлөгдөөгүй гэж 18 хохирогч буюу 90% нь хариулсан байна. Гэхдээ хохирогчдын олонх нь гэмт хэргийн зүйлчлэл гэх ойлголтын талаар мэдлэггүй өөрсдийгөө “хүний наймааны хохирогч” гэж илэрхийлж байсан нь анхаарал татаж байв.

***Үр дүн 10. Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэгт өртөж хохирсон иргэд нэн тэргүүнд хуулийн байгууллагад гэхээсээ илүүтэй төрийн бус байгууллагад хандаж туслалцаа дэмжлэг авах хандлагатай байна. Энэ нь хуулийн байгууллагад итгэх итгэлгүйн дээр тэдний харилцаа хандлагатай зарим талаараа хамааралтай байна.***

Хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэрэгт хохирсон иргэд шууд цагдаагийн байгууллагад хандахаасаа илүүтэй холбон зуучлах үйлчилгээг ТББ-аас авах замаар гомдол мэдүүлсэн байгаа нь судалгааны үр дүнгээс ажиглагдаж байна. Судалгаанд оролцсон 20 хохирогчийн 13 нь цагдаагийн байгууллагад өөрсдөө шууд хандсан, 7 хохирогч нь төрийн бус байгууллагад эхлээд хандсан байна. Эдгээр 7 хохирогчийн 5 нь өмнө нь ямар нэгэн гэмт хэрэгт өртөж хохирч байсан талаар цагдаагийн байгууллагад гомдол гаргаж байсан. Тухайн үед асуудлаа шийдвэрлүүлж чадаагүй нөхцөл байдлын улмаас хуулийн байгууллагад итгэх итгэлээ алдсан гэж хариулжээ.

*Шигтгээ 15.*

*Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон гэдгээ ойлгож мэдээд хамгийн түрүүнд цагдаагийн байгууллагад мэдэгдэж гомдлоо гаргах хэрэгтэй гэж бодсон. Тэгээд гомдлоо гаргаж, хэргээ шүүхээр шийдвэрлүүлсэн.*

*Хохирогчтой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

*Шигтгээ 16.*

*Энэ гэмт хэргийн хохирогч болчихлоо гэдгээ мэдсэн даруйдаа цагдаа, хууль шүүхийн байгууллагад хандъя гэж бодоогүй. Над шиг хүмүүст тусалдаг байгууллага байдаг болов уу гэж сураг ажиг тавьж нэг байгууллага олсон. Тэр байгууллагаас надад өмгөөлөгч авч өгснөөр би хуулийн байгууллагад гомдлоо гаргасан. Ер нь бид хуулийн байгууллагад итгэх итгэл алдарсан байдаг юм билээ.*

*Хохирогчтой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

Хууль хяналтын байгууллагад шууд хандахгүй байгаа нь нэг талаар хохирогчийн эрх зүйн мэдлэгтэй холбоотой бөгөөд нөгөө талаас хууль хяналтын байгууллагын алба хаагчдын харилцаа, хандлагатай хамааралтай гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцсон хохирогчдын олонх нь буюу 83 хувь нь мөрдөн шалгах ажиллагааны явцад болон прокурорын шатанд явагдах үйл ажиллагаатай холбон авч үзсэн байна. Үүнийг дэлгэрүүлэн судлахад хохирогчтой харилцах харилцаа, үйлчилгээнд баримтлах зарчмыг хууль шүүхийн ажилтнууд баримталдаггүй гэж үзсэн байна.

*Шигтгээ 17.*

*Би өмнө нь цагдаагийн байгууллагад өөр хэргээр гомдол гаргаж байсан ч миний гаргасан гомдлыг хүлээж аваагүйн дээр надтай их муухай харилцаж байсан. Тийм болохоор энэ удаагийн хэрэг дээр цагдаад биш надад туслах ТББ-д хандъя гэж бодсон. Гэхдээ надад өмгөөлөгч өгч, өмгөөлөгч маань миний өмнөөс гомдол гаргаж, хэргээ шийдвэрлүүлж чадсан. Гэсэн ч өмнө нь гаргаж байсан харилцаа хэвээрээ л байсан. Юу гэхээр, чи өөрөөсөө л болж хохирсон, чи угаасаа биеэ үнэлэгчийн санд бүртгэлтэй л юм байна шүү дээ гэх зэргээр хэлж байсан нь их хүнд байсан.*

*Хохирогчтой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

Шигтгээ 18.

Би өмнө нь биеэ үнэлдэг байсан нь үнэн. Гэхдээ биеэ үнэлнэ гэдэг нь заавал хүний наймааны хохирогч болох ёстой гэсэн үг биш биз дээ. Мөрдөн байцаагч, прокурор 2 яг ингэж харьцсан. Байцаалтын явцад чи яг юугаараа хохирсон юм бэ, чамайг хэн биеэ үнэлж явж бай гэсэн юм бэ гэх зэргээр загнаж, зандардаг байсан. Заримдаа өмгөөлөгч маань өмөөрдөг байсан.

Хохирогчтой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

Зураг 12. Хуулийн байгууллагад хандсан хохирогчдод учирдаг айдас, дарамт



Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокуророос хохирогчийг биеэ үнэлэгч, өөрийн хүслээр явж гэмт хэргийн хохирогч болсон гэж буруутгахын зэрэгцээ мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа ЭХХШтХ-ийн зарчим, зохих журмын зохицуулалтыг зөрчдөг болох нь харагдаж байна.

Хүснэгт 14. ЭХХШтХ-д заасан зарим зохицуулалт

ЭХХШтХ-ийн зүйл, хэсгийн дугаар	Заалтын томъёолол
1.6 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх	1. Шүүх, прокурор, мөрдөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулийн заалтыг чанд сахина.
1.9 дүгээр зүйл. Эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх	1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглоно. 2. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчээс мэдүүлэг авахдаа тэдэнтэй хүнлэг бусаар харьцаж, нэр төр, алдар хүнд, бие махбод, сэтгэл санаанд хохирол учруулах арга хэрэглэхийг хориглоно.



<p>1.12 дугаар зүйл. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх</p>	<p>1. Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.</p>
<p>25.1 дүгээр зүйл. Мэдүүлэг авах</p>	<p>2. Мөрдөгч мэдүүлгийг мэдүүлэг авах шаардлага хангасан өрөөнд авна. Шаардлагатай бол мэдүүлгийг тухайн хүний байгаа газарт очиж авч болно.</p> <p>4. Мэдүүлэг авах хүмүүсийг тус тусад нь байлгаж мэдүүлэг авах ба мөрдөгч нэг хэрэгт мэдүүлэг авах хүмүүсийг өөр хоорондоо харилцахгүй байх арга хэмжээ авна.</p> <p>13.Мэдүүлэг авах үед хөтөлж, эсхүл тулгаж асуулт тавихыг хориглоно.</p>

Дээр дурдсан хохирогчийн ярилцлагын тэмдэглэл болон хохирогчдод тулгарч буй зүй бус харилцаа, хандлага, хуулийн зохицуулалтын зөрчилдөөнт байдлыг харьцуулан авч үзвэл манай улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч төвтэй аргачлал төдийлөн нэвтрээгүйг харуулж байна.

***Үр дүн 11. Энэ төрлийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах хугацаа харилцан адилгүй байна. Энэ нь тухайн хэргийн нөхцөл байдал, оролцогчдын тоо, нотлох ажиллагааны цар хүрээ болон бүртгэгдэх үедээ гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тогтоогдсон байсан эсэхтэй шууд хамааралтай байна.***

Монгол Улсад хүн худалдаалах хэргээр үүсгэсэн хэргийг шийдвэрлэхэд хэдий хугацааг зарцуулж байгааг хуулийн заалт болон шийдвэрлэгдсэн хавтаст хэргийн материалуудад үндэслэн харьцуулалт хийв. ЭХХШТХ-д зааснаар ХХГХ-ийг дунджаар нэг жилийн дотор хянан шийдвэрлэх боломжтой боловч зарим хүчин зүйлийн шалтгаанаар энэ хугацаа богино эсвэл үүнээс ч урт хугацаа байх хуулийн боломж нээлттэй байна.

Бидний судалсан шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн эрүүгийн 4 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хугацааг харьцуулан авч үзвэл хамгийн багадаа 53 хоног, хамгийн ихдээ 2 жил 5 сар 14 хоногийн хугацаа зарцуулсан байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа нь тухайн хэргийн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн этгээд олдсон эсэх, холбогдогч болон хохирогчийн тоо, тухайн гэмт хэрэг хэдий хэр хугацаанд үргэлжилсэн зэргээс шалтгаалдаг байна.

Мөн судалгаанд оролцсон хохирогчдоос авсан судалгааны үр дүнгээс харвал хэрэг бүртгэлтийн хугацааг 1-3 сар, мөрдөн байцаалтын хугацааг 10-12 сарын хугацаанд явагдсан гэж хариулсан байна.

Хүснэгт 15. Хохирогчдоос авсан судалгааны үр дүн /хугацаа/

Үзүүлэлт	Тоо	Хувь
<b>Хэрэг бүртгэлтийн хугацаа</b>		
1-3 сар	5	25%
10-12 сар	1	5%
6-7 жил	1	5%
Мэдэхгүй	13	65%
<b>Мөрдөн байцаалтын хугацаа</b>		
4-6 сар	1	5%
10-12 сар	6	30%
2-3 жил	2	10%
Мэдэхгүй	11	55%
<b>Прокурорын хяналтын шат</b>		
1-3 сар	2	10%
Мэдэхгүй	18	90%

Хохирогчдын өгсөн мэдээллээс харахад тэд өөрсдийнх нь өртөж хохирсон гэмт хэргийг шалгах ажиллагаа аль үе шатандаа явж байгаа болон ямар хугацаа зарцуулагдаж байгаа талаар тодорхой мэдээлэлгүй байгаа нь Хүснэгт 15-с харагдаж байна. Тодруулбал, нийт 20 хохирогчийн 13 нь хэрэг бүртгэлтийн ажиллагаа, 11 нь мөрдөн байцаалтын ажиллагаа, 18 нь прокурорын хяналтын ажил ямар хугацаанд явагдсаныг тус тус мэдэхгүй гэж хариулсан нь анхаарал татаж байна.

Судалгаанд хамрагдсан 4 хэрэг нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр байгаа хэргүүд юм. Харин судалгаанд хамрагдсан, нийт бүртгэгдсэн гэмт хэргийн талаарх тоон үзүүлэлтэд хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан<sup>17</sup>, хэргийг хэрэгсэхгүй болгосон, мөрдөн байцаалтын ажиллагаанд байгаа, анхан шатны шүүх шийдвэрлэсэн боловч, давж заалдах, хяналтын шатны шүүхүүдэд хянагдаж байгаа учир судалгааны багийнхан танилцах боломжгүй нөхцөл байдал үүссэнээс эцэслэн шийдвэрлэгдсэн 4 хэргийг хамруулсан гэдгийг дурдах нь зүйтэй.


<sup>17</sup> Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан тохиолдол бүртгэгдээгүй

**ХҮН ХУДАЛДААЛАХ, ТҮҮНТЭЙ ТӨСТЭЙ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ  
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

*Хүснэгт 16. Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэргийн талаарх  
нэгтгэсэн мэдээлэл*

Эрүүгийн нэг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгч өөрчлөгдсөн эсэх, тоо	Шүүгч	1	үгүй	үгүй	4					
	Прокурор	5	2	1	үгүй					
	Мөрдөгч	1	үгүй	үгүй	үгүй					
Хэргийн оролцогчдын өмгөөлөгчийн тоо	үгүй	үгүй	1	үгүй	3	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй
Шүүх хуралдаан давтамж, тоо	2		2	1	3					
Хохирогч өөрт учирсан нөхөн төлбөрийг гаргуулах хүсэлт гаргасан эсэх, хохирлыг нөхөн тооцож олгосон байдал	үгүй	үгүй	290518 төгрөг нэхэмжилсэн. Шүүхээс иргэний журмаар шүүхэд хандах эрхийг тайлбарласан	40000 төгрөг нэхэмжилсэн. Шүүхээс иргэний журмаар шүүхэд хандах эрхийг тайлбарласан.	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй
Гэрч, хохирогчийг хамгаалах хүсэлт гаргасан байдал, түүнийг шийдвэрлэсэн эсэх	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй
Хохирогчийг үйлчилгээний байгууллагад хандуулсан байдал, түүнд үзүүлсэн үйлчилгээний төрөл	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй
Хохирогчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал	Хууль ёсны төлөөлөгч	үгүй	үгүй	тийм	тийм	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй
	Өмгөөлөгч	үгүй	үгүй	тийм	үгүй	тийм	үгүй	үгүй	үгүй	үгүй
Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч тусгайлсан хүсэлт гаргасан эсэх, түүнийг шийдвэрлэсэн байдал;	Хохирогч хүсэлт гаргаагүй		Хохирогч хүсэлт гаргаагүй	Хохирогч хүсэлт гаргаагүй	Хохирогч хүсэлт гаргаагүй					
Хохирогчийн мэдүүлэг, байцаалт (давтамж)	3	4	2	2	5	3	2	2	2	4
Хэрэг	X-1	X-2	X-1	X-1	X-1	X-2	X-3	X-4	X-5	X-6
	Хэрэг-1		Хэрэг-2	Хэрэг-3	Хэрэг-4					

Зураг 13. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх хугацааны зураглал



*Шигтгээ 19.*

*Хэрэг бүртгэлтийн анхны хугацаанд нь л шийдэхийг зорьж байгаа. 1-2 сарын хугацаанд л шалгаж шийдвэрлэж байна даа. Мөрдөн шалгах ажиллагаанд төрийн байгууллагуудаас авдаг лавлагаа, шинжилгээний байгууллагаас авдаг дүгнэлт хүлээж хамгийн их хугацаа алддаг.*

*Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

*Шигтгээ 20.*

*ХХГХ болон түүнтэй төстэй гэмт хэргийг шалгахад хугацаа их шаарддаг гэж бодож байна. Яагаад гэвэл бүлэг зохион байгуулалттай, улс орон дамнасан бол мөрдөн шалгах ажиллагаа тодорхой хэмжээгээр удаашрах байхаа.*

*Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

*Шигтгээ 21.*

*Би сүүлийн 2 жил гаруй хугацаанд хүн худалдаалах болон манай хэлтэст харьяалуулан шалгадаг ижил төрлийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Хэрэг бүрд зарцуулах хугацаа өөр өөр. Зарим хэргийн хуулийн анхны хугацаанд шалгаад дуусаж байхад зарим нь 2, 3 жил болсон хэрэг ч байна.*

*Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

Мөрдөн шалгах ажиллагааны хугацаа алдах бас нэг үндэслэл нь гадаад улсад үйлдэгдсэн гэмт хэрэгт нотлох баримт цуглуулахтай холбоотой ажиллагаа юм. ЭХХШТХ-ийн 42.1 дүгээр зүйлд гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, туршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу хүсэлт илгээнэ гэжээ. Энэ нь манай улсаас эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр гэрээ байгуулсан улсад хүн худалдаалах түүнтэй төстэй гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд холбогдох нотлох баримтыг цуглуулж бэхжүүлэх талаар хүсэлтээ илгээн шийдвэрлүүлэх эрх зүйн боломжийг бий болгосон зохицуулалт юм.

УЕПГ-н мэдээлэлд 2018 онд 17, 2019 онд 25, 2020 онд 29 хэрэгт гадаад улсад нотлох баримт цуглуулах хүсэлт илгээсэн гэж дурдсан ч хэргийн зүйл, заалтын талаарх мэдээлэл байхгүй тул чухам хэчнээн хэрэг нь бидний судалгааны объект болохыг харах боломжгүй байна.

Судалгааны ажлын хүрээнд танилцсан эрүүгийн хавтаст хэргийн материалд Монгол Улсын иргэн хэд хэдэн эмэгтэйг БНХАУ улсад ажиллуулах нэрээр худалдсан байсан ба 2015 оны Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн 2.2, 2.3 дахь хэсэгт зааснаар зүйлчилж, уг

хэргийг үйлдсэн Монгол Улсын иргэн 5 жилийн хорих ялаар шийтгүүлжээ<sup>18</sup>. Уг хэргийн хохирогчийн мэдээллийн дагуу "...БНХАУ-ын нутаг дэвсгэр дээрх этгээдүүдийн үйл ажиллагааг нь таслан зогсоолгох, Монгол Улсын иргэдийг авчрах тусламж хүссэн..." талаар хүсэлтийг Интерпол руу явуулсан байна. Интерполоос уг мэдээллийн дагуу байрлалтай газарт ажиллагаа явууллаа. Монгол Улсын 4 эмэгтэй, 2 хятад эмэгтэй байв. Нэр дурдсан холбогдогчийг, 3 эмэгтэйн хамт шалгасан боловч 3 эмэгтэй нь хүчээр биеийг нь үнэлүүлээгүй, мансууруулах бодис хэрэглүүлээгүй, сайн дураараа хийсэн гэсэн тул суллалаа. БНХАУ-ын иргэн 2 эмэгтэйн талаар ямар нэг мэдээлэл ирүүлээгүй байна. Гэхдээ энэ интерполын албан ёсны хариу нь хохирогчийн мэдүүлгийн эх сурвалж болсноос гадна БНХАУ-ын тухайн газарт биеэ үнэлэх, үнэлүүлэх ажиллагаа явагдаж байсан, Монгол Улсын иргэн эмэгтэйчүүд биеэ үнэлж байсан, холбогдогч этгээд эмэгтэйчүүдийг Монгол Улсаас Хятад улс руу нь худалдаалдаг нь тогтоогдсон тул хэрэг эцэслэн шийдвэрлэгджээ.

*Шигтгээ 22.*

*Эрүүгийн цагдаагийн албанд шалгагдаж байсан хүн худалдаалах 1 хэрэгт БНХАУ-н нутаг дэвсгэр дээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлага гарч байсан. Тэгээд холбогдох бичиг баримтыг бүрдүүлээд УЕПГ-аас хүсэлт илгээсэн боловч нөгөө талаас 3 сар гаруйн хугацааны дараа Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор явуулсан даалгаврыг гүйцэтгэх боломжгүй байна гэсэн хариу ирж байсан удаатай.*

*Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

Судалгаанд оролцсон 20 хохирогчийн 12 буюу 60 хувь нь дотоодод, 9 буюу 45 хувь нь гадаадад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон бөгөөд Малайз улсад 3, Филиппин улсад 2, БНХАУ-д 3, Испани улсад 1 хүн тус тус хохирогч болсон байна.

*Хүснэгт 17. Хуулийн байгууллагад хандсан 20 хохирогчдын хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн газар зүйн байршил*

Байршил		Хохирсон хүний тоо	Эзлэх хувь
Монгол		12	60%
Гадаад	Малайз	3	15%
	Филиппин	2	10%
	БНХАУ	2	10%
	Испани	1	5%

Гэвч Монгол Улс эдгээр улсуудаас БНХАУ-аас бусад улсуудтай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулаагүй нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай нотлох баримтыг тухайн улсаас цуглуулж бэхжүүлэхэд хүндрэл учрах, цаашлаад тийм боломжгүй болох нөхцөлийг бүрдүүлж байна.

<sup>18</sup> 2017....057 дугаартай хавтаст хэргийн материалаас...

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширч буй бас нэг нөхцөл нь мөрдөгч, прокурор солигдох явдал юм. Өөрөөр хэлбэл ЭХХШТХ-ийн 4.1 дүгээр зүйлийн 2.13 дахь заалтад ... хэргийг өөр мөрдөгч, прокурорт шилжүүлэх шийдвэр гаргах эрхтэй гэж заасны дагуу прокуророос тухайн хэргийн мөрдөгч, хяналт тавьж буй прокурорыг сольж болохоор хуульчилсан бөгөөд дараах үндэслэл илэрсэн байхыг шаардана. Үүнд:

- оролцогчийн хувиар тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа, эсхүл оролцохоор бол;
- тухайн хэргийн шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч, оролцогчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн бол;
- өмнө нь тухайн хэрэгт шүүгч, прокурор, мөрдөгч, оролцогч, бусад оролцогч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар оролцсон бол;
- өөрөө шууд, эсхүл шууд бусаар энэ хэрэгт хувийн сонирхолтой байна гэж үзэх бусад үндэслэл байгаа бол зэрэг болно.

Хуулийн байгууллагад хандаж хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчоор тогтоогдсон 20 хохирогчтой ганцаарчилсан ярилцлагын үр дүнгээс үзэхэд хэрэг бүртгэгч солигдсон гэж 2, мөрдөгч солигдсон гэж 11, прокурор солигдсон гэж 1 хүн хариулсан бол шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн 4 хэргийн тухайд мөрдөгч солигдсон 1, прокурор солигдсон 8, шүүгч солигдсон 5 тохиолдол гарсан байна.

Хэдийгээр хуулиар эрх бүхий албан тушаалтан мөрдөгч, прокурорыг солих бүрэн боломжтой ч энэ нь шинээр хэргийг хүлээн авсан мөрдөгч, прокурор хэргийн материалтай танилцах, шалгах төлөвлөгөө боловсруулах, оролцогчдоо тодорхойлох зэрэг өмнө нь хийгдсэн ажиллагааг дахин хийх нөхцөлийг бий болгож улмаар мөрдөн шалгах ажиллагааны болон прокурорын хяналтын хугацаа алддаг байна.

***Үр дүн 12. Мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогчдоос хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах, өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах, мэдээллээр хангуулах, аюулгүй байдлаа хамгаалуулах боломж хязгаарлагдмал байна.***

ЭХХШТХ-ийн 8.2 дугаар зүйлд хохирогч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /цаашид ЭХХША гэх/-ны явцад өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй хэмээсэн ч энэ хэргийн хохирогч нарт хэрэгждэггүй байна. Бидний судалсан нийт 10 хохирогчтой 4 эрүүгийн хавтаст хэрэгтэй танилцахад 8 хохирогч нь огт өмгөөлөгчгүйгээр ЭХХША-нд оролцож, 2 хохирогч нь анхан болон давж заалдах шатны шүүх хуралд л өмгөөлөгчтэй оролцсон байна.

Нийт хохирогчдын 9 нь огт мэргэжилгүй, 7 нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 2 нь ерөнхий боловсролын сургуулийн сурагч байх үедээ гэмт хэргийн хохирогч болсон байна. Эндээс хохирогчдын амьдралын нөхцөл байдлыг

харж болох бөгөөд тэд бүгд өмгөөлөгч авах боломж хязгаарлагдмал, эдийн засгийн эмзэг байдалтай болох нь харагдаж байна.

Хуулийн байгууллагад хандсан 20 хохирогчийн 9 буюу 45% нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчтэй оролцсон бөгөөд бусад нь өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авч байгаагүй гэсэн байна.

*Шигтгээ 23.*

*Хохирогч хүүхэд бол асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг заавал оролцуулж, өмгөөлөгч авах эрхтэй болохыг тайлбарладаг, харин хохирогч насанд хүрсэн бол өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч авах эрхийг нь мөн тайлбарладаг. Хэрэв өмгөөлөгч авах хүсэлтэй боловч авч чадахгүй байгаа тохиолдолд Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудад хандахыг зөвлөдөг, зарим тохиолдолд холбож өгдөг. Тухайн төрийн бус байгууллагууд нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой голчлон ажилладаг, туршлагатай өмгөөлөгчидтэй холбоотой байдаг ба тэд өмгөөлөгч авахад нь тусалдаг.*

*Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

*Шигтгээ 24.*

*Харилцан адилгүй хохирогчийн хувийн байдлаас шалтгаалан өмгөөлөгч яаж оролцуулахаа шийдвэрлэнэ.*

*Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

*Шигтгээ 25.*

*Хохирогчдыг өмгөөлүүлэхээр хууль зүйн туслалцааны төв, төрийн бус байгууллагад ханддаг. Зарим тохиолдолд ЭХХША-нд хохирогч өмгөөлөгчгүй оролцдог.*

*Прокурортой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

*Шигтгээ 26.*

*Хөндлөнгийн байр суурьтай оролцдог шүүхийн хувьд өмгөөлөгчийн асуудалд оролцох боломж хязгаарлагдмал. 2002 оны Эрүүгийн хуулиар хэрэг шийдвэрлэж байх үед хохирогч өмгөөлөгчтэй оролцмоор байгаагаа, төлбөрийн боломжгүй учир авч чадахгүй байгаагаа илэрхийлсэн тохиолдолд Хуульчдын холбоо руу хандаж, өмгөөлөгч томилуулдаг. Сүүлийн үед тус холбооны эрх зүйн туслалцаа үзүүлэх хороонд хандан өмгөөлөгчийнх нь асуудлыг шийдвэрлэж байна.*

*Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан оролцогчдоос 11 прокурор, 5 мөрдөгч мөрдөн шалгах ажиллагааны явцад хуульд заасны дагуу хохирогчдыг өмгөөлөгчтэй оролцуулах боломжоор хангадаг гэж байгаа боловч энэ нь бодит байдалд үгүйсгэгдэж байна.



Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэрэгт өмгөөлөгчөөр ажиллаж байсан туршлагатай шалтгаанаар сонгогдсон 6 өмгөөлөгчтэй ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулсан бөгөөд тэдний 3 нь сүүлийн 3 жилийн хугацаанд 1-3 хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлсэн байгаа нь хохирогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх явдал хангалтгүй байгааг харуулж байна.

УИХ-аас 2013 онд төлбөрийн чадваргүй яллагдагчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тогтоох зорилгоор Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийг батлан гаргасан<sup>19</sup>. Гэвч төлбөрийн чадваргүй хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин байхгүй, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам өнөөг хүртэл батлагдаагүй учир хуулийн байгууллагад хандсан хохирогчдод өмгөөллийн туслалцаа авч чадахгүй байсаар байна.

ЭХХШТХ-ийн 9.5 дугаар зүйлд зааснаар арван найман насанд хүрээгүй хохирогчийн тухайд түүний төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг; хэрэв ийм хүн байхгүй эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоохоор заасан. Судалгааны хүрээнд танилцсан 2 хэргийн насанд хүрээгүй 1 хохирогчийнх нь эцгийг, нөгөө хохирогчийнх нь анги удирдсан багшийг хууль ёсны төлөөлөгчөөр томилон мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулсан байна.

Хэдийгээр төрөөс насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ өмгөөлөл, хууль зүйн туслалцаатай холбоотой асуудлыг орхигдуулсан ч хууль ёсны төлөөлөгчийг оролцуулах эрх зүйн орчныг бий болгосон байна. Гэвч хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон этгээд, ялангуяа Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллагаас томилогдон оролцож байгаа төрийн албан хаагч нь үндсэн үүрэгт ажлын хажуугаар энэхүү үйл ажиллагаанд оролцдог тул мөрдөн шалгах ажиллагаанд тууштай, мэдлэг бүхий байдлаар анхаарч чадахгүй байгаа нь ярилцлагаас ажиглагдав. Цаашид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хохирогчдод тэр дундаа насанд хүрээгүй хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлдэг, дагнасан, мэргэшсэн, тусгай алба хаагч, мэргэжилтэн бэлтгэх, хүний нөөцийг чадавхжуулах ажилд анхаарлаа хандуулах хэрэгцээ шаардлага бий болсон байгааг харуулж байна.

---

<sup>19</sup> Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2013, №30

Шигтгээ 27

*Хүүхэд хохирсон хэрэгт эцэг эхийг нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзээд бараг оролцуулдаггүй. Харин гэр бүлийн газраас хууль ёсны төлөөлөгч оролцуулж байгаа. Ингэж оролцож байгаа хүн нь ажлынхаа хажуугаар явдаг учраас чанартай сайн ажиллаж чадахгүй байна гэж үздэг. Тухайн хүүхэдтэй холбоотой мөрдөн шалгах ажиллагаа явуулахад л ирж ажиллачхаад явчихдаг. Энэ талаар бас судлах, шийдэх хэрэгтэй байх*

*Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

Төр ийнхүү төлбөрийн чадваргүй хохирогчийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг орхигдуулсныг үйлчилгээ үзүүлэгч ТББ-ууд нөхөж, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийнхөө хүрээнд мэргэшсэн өмгөөлөгч хөлсөлж байгаа нь бусад судалгааны тайлан<sup>20</sup>-аас харагдаж байна. Эдгээр байгууллагуудаас ганцхан жишээ дурдахад Хүйсийн тэгш эрх төв ТББ нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон охид, эмэгтэйчүүдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалан ажиллах өмгөөлөгчдийг ажиллуулдаг бөгөөд тэдгээрийн өмгөөллийн хөлсийг хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрөөсөө санхүүжүүлж байна.


ЭХХШТХ-ийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар шүүх, прокурор, мөрдөгч хохирогчоор тогтоох тухай шийдвэр гарсны дараа түүнд мөн хуулийн 8.2 дугаар зүйлд заасан эрх, үүргийн тайлбарлаж өгөхөөр зохицуулсан. Хэдийгээр мөрдөгч, прокурор, шүүхээс энэ үүргээ хэрэгжүүлж, хохирогчоор тогтоосон тогтоолд гарын үсэг зуруулж баталгаажуулж байгаа боловч өмгөөлөгчгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог нь зарим эрхээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна. Тухайлбал, ЭХХШТХ-ийн 8.3 дугаар зүйлд заасан мэдээллээр хангуулах, 8.4 дүгээр зүйлд заасан аюулгүй байдлаа хамгаалуулах эрхээ хэрэгжүүлж чадахгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Хуулийн байгууллагад хандсан хохирогчдын 13 буюу 65 хувь нь тухайн хэргийн явц, шийдвэрлэлттэй холбоотой мэдээллийг авч байгаагүй, 14 буюу 70 хувь нь өмгөөлөгч авах, төрийн болон төрийн бус байгууллагын үйлчилгээнд хамрагдах, хуулийн дагуу хамгаалалт авах боломжтой талаар мэдээгүй гэж хариулсан байна.

Гэтэл эдгээр 20 хохирогчийн 13 буюу 65 хувь нь ямар нэг байдлаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийн зүгээс ирэх дарамт шахалттай учирч байсан нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

<sup>20</sup> Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Иргэдэд туслах хүний эрхийн төв ТББ, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа", УБ.,2017

Зураг 14. Хохирогчдод учирч байсан дарамт, заналхийлэл



Хохирогч нарын хууль эрх зүйн талаар мэдлэггүй байдал, өмгөөлөгчгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог байдал, мөрдөгч, прокуророос хуульд заасан эрх, боломж нөхцөлийн талаар мэдээлэл өгдөггүй байдал нь хохирогчоос аюулгүй байдлаа хамгаалуулах талаар хүсэлт гаргахгүй байх нэг нөхцөл болж байна гэж судалгааны баг үзэж байна.

УЕПГ-ын төв архивд хадгалагдаж байгаа, шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн эрүүгийн 4 хэргийн хохирогчид ч мөн адил аюулгүй байдлаа хамгаалуулах талаар хүсэлт гаргаагүй байсныг Хүснэгт 16-д үзүүлсэн болно.

***Үр дүн 13. ХХГХ болон түүнтэй төстэй хэргийн хохирогчид өөрт учирсан хохирлоо тодорхойлох, түүнтэй холбоотой баримтыг хэрхэн гаргах, ямар байдлаар нөхөн төлүүлж болох талаар мэдлэг, ойлголтгүйн улмаас хохирлоо нэхэмжилж чадахгүй байна.***

Аливаа гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хохирогч нь гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах эрхтэй байдаг. Эрх зүйн орчны хувьд сэтгэл санааны хохирлыг тооцож болохоор байгаа боловч мөрдөн шалгах ажиллагааны явцад сэтгэл санааны хохирлыг тогтоох, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэхэд шаардлагатай нотлох баримт хангалтгүй цуглуулж байгаагаас хохирогч өөрт учирсан сэтгэл санааны хохирлоо тооцуулж чадахгүй, сэтгэл санааны хохирол учирсан гэж тооцсон ч түүнийг зөрчигдсөн эрхийг нь сэргээн эдлүүлэх ажиллагаа хийгддэггүй нь танилцсан хавтаст хэргийн материал болон судалгаанд оролцсон мөрдөгч, прокурор, шүүгч нартай хийсэн ярилцлагаас тодорхой харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан шүүгч, прокуророос өгсөн мэдээлээс үзвэл хохирогч нар нь өмгөөлөгчтэйгөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон тохиолдолд л сэтгэл санааны хохирлыг нэхэмжилж байна. Гэхдээ сэтгэл санаанд ямар хэмжээний хохирол учирсныг зөвхөн өөрийн (хохирогчийн) үзэмжээр тайлбарлаж, мөнгөн дүнг илэрхийлдэг. Гэвч өөрт учирсан сэтгэл санааны хохирлыг үндэслэлтэйгээр нэхэмжлэх, түүнийг нотлох байдал хангалтгүй байх тул шүүхээс сэтгэл санааны хохирлыг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар жич нэхэмжлэх эрхийг нь зааж шийдвэрлэж байна гэжээ.

Мөрдөгчдийн хувьд сэтгэл санааны хохирол учирсан гэдгийг тэр бүр тогтоогоод байдаггүй бөгөөд сэтгэл санааны хохирол учирсан эсэхийг тогтоох нотлох баримт цуглуулдаггүй байна.

*Шигтгээ 28.*

*Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэргийн хохирогчийн нэхэмжилсэн эмчилгээний зардал 290,000 төгрөгийг шүүх шүүгдэгчээс гаргуулахаар шийдвэрлэж харин сэтгэл санааны хохиролд нэхэмжилсэн 8,000,000 төгрөгийг нотлох баримтаа бүрдүүлэн иргэний хэргийн шүүхээр нэхэмжлэх эрхтэй хэмээн нээлттэй үлдээж шийдвэрлэсэн байна.*

*180...195 дугаартай хэргийн материалаас...*

*Шигтгээ 29.*

*Хүний сэтгэл санааны хохирлыг ямар байдлаар барагдуулах чиглэлээр хуульд тодорхой ойлгомжтой заалт, аргачлал одоогоор байхгүй, харин эрүүл мэндэд учирсан хохирлыг баримттай байх юм бол мөрдөн шалгах ажиллагааны үед юм уу, прокурор, шүүхийн шатанд барагдуулах боломжтой. Сэтгэл санааны хохирлыг тогтооход мэргэшсэн сэтгэл зүйч тухайн хохирогчийн сэтгэл санааны ямар байдлаар хохирсныг үе шат бүрд ангилж байж хохирлыг нь тогтоох нь зүйтэй гэж үзэж байна.*

*Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

Судалгааны ажлын хүрээнд танилцсан 4 хэрэгт хохирогчоор тогтоогдсон 10 хохирогчийн зөвхөн нэг нь л эмчилгээний болон сэтгэл санааны хохирол нэхэмжилсэн байгаагаас үзвэл хохирогчдын энэ талаарх мэдлэг ойлголт муу байгааг илтгэж байна.

Түүнчлэн хуулийн байгууллагад хандсан 20 хохирогчийн 3<sup>21</sup> нь сэтгэл санааны хохирол гэж нийт 51 сая 800 мянган төгрөг нэхэмжилжээ. Үлдсэн 17 хохирогчдын хувьд огт нэхэмжлэл гаргаагүй бөгөөд нэхэмжлэл гаргаагүй шалтгаанаа дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

*Хүснэгт 18. Хохирогчдын нэхэмжлэл гаргаагүй шалтгаан*

Шалтгаан	Тоо	Хувь
Гэмт хэрэг үйлдсэн этгээдээс авах хөрөнгө байхгүй	1	5%
Нэхэмжлэл гаргах эрхтэй гэж мэдээгүй	3	15%
Нотлох баримт байхгүй	5	25%
Хэргийг хэрэгсэхгүй болгосон	1	5%
Хариулаагүй	10	50%

<sup>21</sup> Нэг хохирогч 49 сая төгрөг, нэг хохирогч 1,8 сая төгрөг, нэг хохирогч 1 сая төгрөг нэхэмжилсэн байна.

ХХГХ-ийн зарим хохирогч гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах эрхтэй гэдгээ мэдэхгүй байгаа нь мөрдөгчөөс ЭХХШТХ-д заасан хохирогчоор тогтоосон тогтоолыг танилцуулахдаа түүний эрх, үүргийг тайлбарлаж өгөх явдал хангалтгүй байгаа, түүнчлэн өмгөөлөгчгүй байхтай холбоотой гэж үзэхээр байна.

### **2.3. ШҮҮХЭЭР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА**

Монгол Улсын Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулагдан хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, заавал биелүүлэх шийдвэр гаргадаг шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг шүүх гэнэ.

Шүүх нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хууль байгууллыг бататган бэхжүүлж, хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хууль дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах эрхэм зорилгоор үйл ажиллагаагаа явуулна<sup>22</sup>.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот болон 21 аймагт нутаг дэвсгэрийн харьяаллаар ажиллаж байгаа эрүүгийн хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүх ЭХХШТХ-д заасан үндэслэл, журмын дагуу хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

***Үр дүн 14. Шүүхээс хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийг шийдвэрлэж буй тоон үзүүлэлт жил бүр өсөж байгаа нь сайн үзүүлэлт юм. Гэвч энэ нь нийт бүртгэгдсэн, шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн тоотой харьцуулахад цөөн байна.***


Цагдаагийн байгууллагад 2017-2021 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик, прокурорын болон шүүхийн статистик мэдээллийн хооронд бүртгэгдсэн гэмт хэрэг болон шийдвэрлэсэн хэргийн хооронд ихээхэн зөрүүтэй байгаа нь анхаарал татаж байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүн худалдаалах болон түүнтэй төстэй хэргүүдийн шийдвэрлэлтийн талаар тус бүрд нь авч үзвэл:

---

<sup>22</sup> Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ., 2021, №5

Зураг 15. Хүн худалдаалах гэмт хэргийн хөдөлгөөн




Эндээс харвал 2017-2021 онд ХХГХ нийт 76 бүртгэгдэж, үүнээс 43 хэргийн хэрэг бүртгэлийг хааж, 1 хэргийг хэрэгсэхгүй болгож, 3 хэргийг нэгтгэж<sup>23</sup> шийдвэрлэсэн байна.

Харин шүүхээр хянан хэлэлцүүлэхээр 12 хэргийг шилжүүлж, үүнээс 4 хэргийг шүүх эцэслэн шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл ХХГХ гэж бүртгэгдсэн хэргүүдийн дийлэнх нь буюу 56.5% нь гэмт хэрэг биш гэж тооцогддог байна. Нийт 14 гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байна.

Зураг 16. Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хөдөлгөөн

**Улсын хэмжээнд 2017-2021 онд Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг 39 бүртгэгдсэнээс**



<sup>23</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.2 дугаар зүйл. Эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах

1.Хэд хэдэн яллагдагч нэг, эсхүл хэд хэдэн гэмт хэргийг хамтран үйлдсэн, эсхүл нэг яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол үйлдэл тус бүрд нь эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, мөрдөн байцаалт явуулна.

2.Хэд хэдэн яллагдагч нэг, эсхүл хэд хэдэн гэмт хэргийг хамтран үйлдсэн, эсхүл нэг яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол хэргийг нэгтгэж мөрдөн байцаалт явуулж болно.

2017-2021 онд бэлгийн мөлжлөгийн 39 гэмт хэрэг бүртгэгдэж, үүнээс 22 хэргийн хэрэг бүртгэлтийг хааж, 1 хэргийг хэрэгсэхгүй болгож, 1 хэргийг нэгтгэж шийдвэрлэсэн байна. Харин шүүхээр хянан хэлэлцүүлэхээр 11 хэргийг шилжүүлж, үүнээс 2 хэргийг шүүх эцэслэн шийдвэрлэсэн байна. Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн 58.9% нь гэмт хэрэг биш гэж тооцогддог байна. Нийт 4 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

*Зураг 17. Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн хөдөлгөөн*

### **Улсын хэмжээнд 2020-2021 онд биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг 30 бүртгэгдсэн**



2020 оны 01-р сард Эрүүгийн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Биеэ үнэлэхийг зохион байгуулах<sup>24</sup>-ыг гэмт хэрэгт тооцох болсон. Энэ гэмт хэргийг үйлдэхдээ арван найман насанд хүрээгүй хүнийг биеийг үнэлүүлсэн бол энэ хуульд заасан хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарна.

2020-2021 онд биеэ үнэлэхийг зохион байгуулах 30 гэмт хэрэг бүртгэгдэж, үүнээс 15 хэргийн хэрэг бүртгэлтийг хааж, 4 хэргийг нэгтгэж шийдвэрлэсэн байна. Харин шүүхээр хянан хэлэлцүүлэхээр 6 хэргийг шилжүүлж, үүнээс 3 хэргийг шүүх эцэслэн шийдвэрлэсэн байна. Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн 50.0% нь гэмт хэрэг биш гэж тооцогддог байна. Нийт 5 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.


<sup>24</sup> Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйл буюу Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэдэгт бусдыг биеэ үнэлэхэд зуучилсан, татан оролцуулсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаардах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ ... биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд нь тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлээр хангасан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэжээ.

Зураг 18. Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн хөдөлгөөн




2017-2021 онд албадан хөдөлмөрлүүлэх 4 гэмт хэрэг бүртгэгдсэн ч 4-үүлээ хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсад албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргээр шүүхээр шийдвэрлэсэн 1 ч хэрэг байхгүй нь үүгээр батлагдаж байна.

Зураг 19. Хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах гэмт хэргийн хөдөлгөөн



2017-2021 онд хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах нэг гэмт хэрэг бүртгэгдсэн ч хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсад энэ төрлийн гэмт хэргээр шүүхээр шийдвэрлэсэн нэг ч хэрэг байхгүй нь үүгээр батлагдаж байна<sup>25</sup>.

Зураг 20. Хүүхдээр гуйлга гуйлгах гэмт хэргийн хөдөлгөөн




2017-2021 онд хүүхдээр гуйлга гуйлгах нэг гэмт хэрэг бүртгэгдсэн ч хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн байна.

<sup>25</sup> 2017 оноос өмнө нь энэ гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэж байсан тохиолдол байхгүй билээ.




Зураг 21. Хүүхэд худалдах гэмт хэргийн хөдөлгөөн



2017-2021 онд хүүхэд худалдах хоёр гэмт хэрэг бүртгэгдсэн ч хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн байна.

Зураг 22. Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэргийн хөдөлгөөн



2017-2021 онд хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэг 61 бүртгэгдэж, үүнээс 25 хэргийн хэрэг бүртгэлтийг хааж, нэг хэргийг хэрэгсэхгүй болгож, 7 хэргийг нэгтгэж шийдвэрлэсэн байна. Харин шүүхээр хянан хэлэлцүүлэхээр 22 хэргийг шилжүүлж, үүнээс 6 хэргийг шүүх эцэслэн шийдвэрлэсэн байна. Энэ төрлийн гэмт хэргийн 42.6% нь гэмт хэрэг биш гэж тооцогддог байна. Нийт 5 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Зураг 23. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах гэмт хэргийн хөдөлгөөн



2017-2021 онд хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах 3 гэмт хэрэг

бүртгэгдэж, үүнээс нэг хэргийн хэрэг бүртгэлтийг хааж, 2 хэргийг нэгтгэж шийдвэрлэсэн байна.

Зураг 24. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийн хөдөлгөөн



2017-2021 онд хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэг 26 бүртгэгдэж, 23 хэргийн хэрэг бүртгэлтийг хааж, 2 хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэж, ажиллагаанд нэг хэрэг байна.

Шүүхээр шийдвэрлэсэн хүн худалдаалах болон түүнтэй төстэй хэргийн шийдвэрлэлтийг тусад нь авч үзвэл хүн худалдаалах гэмт хэрэг 4, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг 2, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг 3, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэг 6, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэрэг 2 тус тус эцэслэн шийдвэрлэгдсэн байна<sup>26</sup>.

Зураг 25. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн шийдвэрлэлтийн инфо-график




Тодруулбал, 2017-2021 онд цагдаагийн байгууллагад хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэг нийт 241 бүртгэгдэж, 3 хэрэг хэрэгсэхгүй болж, 137 хэргийн хэрэг бүртгэлтийг хаасан нь нийт гэмт хэргийн 58% нь мөрдөн байцаалтын болон прокурорын хяналтын шатанд дуусгавар болж байгаа нь харагдаж байна. Харин шүүхэд 53 хэргийг шилжүүлснээс 17 хэргийг шүүх эцэслэн шийдвэрлэсэн байна.

Прокурорын байгууллагаас ирүүлсэн мэдээллээр зөвхөн 2021 онд бүртгэгдсэн хүн худалдаалах түүнтэй төстэй нийт 44 гэмт хэргийн 12 буюу 3-4 хэрэг тутмын 1 нь хэрэгсэхгүй болох, хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн байна.

<sup>26</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлагаас авсан мэдээ

Зураг 26. 2021 онд хүн худалдаалах болон түүнтэй төстэй хэргийг хэрэгсэхгүй болгосон, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан харьцуулалт



Судалгааны багаас хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн шийдвэрлэлт, ялангуяа хэрэгсэхгүй болгосон (ХБ), хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан (ХБХХаасан), түдгэлзүүлсэн тохиолдлуудын хууль зүйн үндэслэлийн талаар дэлгэрэнгүй судалгаа авахаар Прокурорын байгууллагад хүсэлт хүргүүлсэн боловч энэ талаар мэдээлэл огт ирээгүй болно.

Шүүхэд шилжүүлсэн хэргүүд бүгд шийдвэрлэгдэж чадахгүй байгаа нь тухайн гэмт хэргийн онцлогоос гадна 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байгаа ЭХХШТХ-ийн талаарх холбогдох албан хаагчдын ойлголт харилцан адилгүйгээс хүн худалдаалах хэргийг өөр зүйл ангиар зүйлчлэх зэргээр гэмт хэрэгтнүүдэд хөнгөн ял оноох эрсдэлүүд байна.

Түүнчлэн АНУ-ын Төрийн департаментын Хүн наймаалах асуудлын төлөв байдлынтухай 2019 оны тайланд дурдсанаар шүүхийн ажилтнуудын Эрүүгийн хуулийн хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой тодорхой заалтуудын талаарх ерөнхий мэдлэг, ойлголт дутмаг байдгаас зарим хэргүүдэд хөнгөн ял шийтгэл оногдуулахад хүргэж байгааг дурдаж байсан нь 2021 оны тайланд мөн дурдагдсан байна. Тухайлбал, “Эрүүгийн хуулийн 13.1-р зүйлээр хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалахыг гэмт хэрэгт тооцдог болсон. 13.1-р зүйлд хүн худалдаалах гэмт хэргийг насанд хүрсэн хүний эсрэг үйлдсэн бол 2-8 жилийн хорих ял, хүүхдийн эсрэг үйлдсэн бол 5-12 жил хүртэлх хугацаагаар хорих ял оноохоор заасан. Эдгээр ял шийтгэл нь хангалттай чанга бөгөөд бэлгийн

мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн ял нь хүчин гэх мэт бусад хүнд гэмт хэрэгт оногдуулдаг ялтай дүйцэхүйц хүнд заалт болсон. Эрүүгийн хуулийн 12.3-р зүйлд бэлгийн мөлжлөгийг гэмт хэрэгт тооцсон бөгөөд үүнд бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах зарим хэлбэрийг мөн хамааруулсан. 12.3-р зүйлд бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийг 14-өөс дээш насны хүний эсрэг үйлдсэн бол 2-8 жилийн хорих ял, 14-өөс доош насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол 12-20 жил хүртэлх хугацаагаар хорих ял оноохоор заасан. Өмнөх жилүүдийн нэгэн адил эрх бүхий байгууллагаас заримдаа хүн худалдаалах гэмт хэргийг яллахдаа хөнгөн ялаар зүйлчилсэн байна” гэжээ.

*Шигтгээ 30.*

*Сургалтуудаас олж авсан тодорхой хэмжээний мэдлэгтэй байх. Гэхдээ нийт шүүгчдийн дунд хэлэлцүүлэг зохиох нь энэ төрлийн гэмт хэргийг нэг мөр ойлгон шийдвэрлэхэд ач холбогдолтой.*

*Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

*Шигтгээ 31.*

*Энэ төрлийн гэмт хэргийн талаарх суурь ойлголтуудыг сайжруулах, нэр томъёо бүрийг тодорхой болгох, ойлголтыг сайжруулах шаардлагатай байна.*

*Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

*Шигтгээ 32.*

*ХХГХ болон түүнтэй төстэй хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг илүү сайжруулахын тулд сургалтууд сайн явуулах /бусад гэмт хэргээс ялгагдах онцлог, төрөл, хэрхэн шийдвэрлэх боломжтой/.*

*Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

**Үр дүн 15. Шүүхийн байгууллагад ХХГХ, түүнтэй төстэй хэргийг дагнан шийдвэрлэх шүүгч байхгүй ч ийм төрлийн дагнасан шүүгч ажиллах хэрэгцээ шаардлага одоогоор байхгүй гэж шүүгч нар үзэж байна.**

Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно гэж заасан<sup>27</sup>. Энэ ч утгаараа тодорхой төрлийн гэмт хэргийг дагнан шийдвэрлэх чиг үүрэг бүхий шүүх байгууллага эсхүл тийм бүтэц бий болгох нь хуулиар хориглосон болох нь харагдаж байна.

Судалгаанд оролцсон 14 шүүгчийн 12 нь энэ төрлийн гэмт хэргийн дагнан шийдвэрлэх шүүгчийн хэрэгцээ шаардлага байхгүй гэж үзсэн байна.

<sup>27</sup> Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ., 1992, №1

*Зураг 27. ХХГХ болон түүнтэй төстэй хэргийг дагнан шийдвэрлэх шүүгчийн албан тушаал шаардлагагүй гэж үзсэн шүүгчдийн гаргасан үндэслэл*



Энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон хүний сэтгэл зүй, онцлогийг ойлгоогүйгээс хохирогчийн сэтгэл зүйг бүрэн хамгаалж чаддаггүй, хохирогчийг хамгаалах аргуудыг оновчтой, зөв хэрэглээгүйгээс шалтгаалж хохирогч мэдүүлгээсээ буцдаг зэрэг шалтгааныг харгалзан дагнуулан хянан шийдвэрлүүлэх шаардлагатай гэж хоёр шүүгч үзжээ. Харин 12 шүүгчийн 7 нь дагнасан шүүх байгуулах шаардлагагүй бөгөөд энэ төрлийн хэргийг шүүхэд ирэхэд хянан шийдвэрлэдэг мэргэшсэн шүүгч /энэ төрлийн хэргийг хүлээн авдаг, илтгэдэг/ байж болно гэж үзжээ.

Өөрөөр хэлбэл энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдэгдэж буй арга, нөхцөл байдлын талаарх шүүгчдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх замаар хохирогч хамгааллын асуудлыг хангалттай сайн шийдвэрлэх талтай гэж үзэхээр байна.

**Үр дүн 16. Шүүхээс ХХГХ болон түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх хугацаа харилцан адилгүй байна.**

ЭХХШТХ-д зааснаар прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийг хүлээж аваад 15 хоногийн дотор яллагдагчийг шүүхэд шилжүүлэх<sup>28</sup> /шаардлагатай бол 30 хүртэл хоногоор сунгана/, ийм шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх<sup>29</sup> хуулийн зохицуулалттай. Өөрөөр хэлбэл прокуророос шүүх рүү шилжүүлсэн хэргийг хүлээн авч хянан шийдвэрлэх хүртэл 34-64 хоног зарцуулах боломжтой байгаа хэдий ч шүүх хуралдааны үед гарсан хүсэлтүүдийг шийдвэрлэх, тодорхой шалтгаанаар шүүх хуралдааныг хойшлуулах зэрэг шалтгаанаар үүнээс ч их хугацаа зарцуулах тохиолдол байсаар байна.

Бидний судалсан эрүүгийн 4 хэргийг анхан шатны шүүх прокуророос хүлээж авснаас хойш шийдвэрлэх хүртэл 1-10 сарын хугацааг зарцуулжээ. Анхан шатны шүүхийн шийдвэр гарснаас хойш давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэр гарах хүртэл 3-9 сарын хугацааг зарцуулсан ба

<sup>28</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. 2017 он

<sup>29</sup> Мөн тэнд

шүүхийн нийт хугацааг харвал 4-19 сарын хугацаа зарцуулсан нь харагдаж байна<sup>30</sup>.

Хуулийн байгууллагад хандсан 20 хохирогчийн өгсөн мэдээллээс харвал 7 хохирогчийн хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн бөгөөд тэдний үзэж байгаагаар шүүхийн ажиллагаа 1-3 сар үргэлжилсэн гэж нэг, 10-12 сар үргэлжилсэн гэж дөрөв, 4-5 жил үргэлжилсэн гэж нэг хүн хариулжээ.

Шүүхийн байгууллагад хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширч байгаа дараах шалтгаан байна гэж үзэв. Үүнд:

- ✓ энэ төрлийн гэмт хэргийн нэг шүүгдэгч биш, хэд хэдэн хүн хамтран үйлдэгддэг,
- ✓ шүүгдэгч бүр шүүх хуралдааныг хойшлуулахуйц хүсэлт гаргадаг /хохирогчийг оролцуулах, өмгөөлөгчөө солих, өмгөөлөгчтэйгөө оролцох, гэрч оролцуулах.../,
- ✓ хохирогч нь олдохгүй болдог /эмзэг байдалтай холбоотойгоор оршин суух газраа байдаггүй, гэр бүлтэй болоод өөрсдөө зайлсхийдэг, шүүгдэгчтэй таарах нөхцөл байдлаас зугтаадаг, зарим хохирогч нь сайн дурын үндсэн дээр үргэлжлүүлэн биеэ үнэлж байгаа өгүүлэмжийг шүүгдэгч, гэрч нар шүүх хуралдаанд хэлдэг/,
- ✓ өмгөөлөгч хойшлуулах хүсэлт гаргадаг /өвчтэй, сургалттай, шүүх хуралдаан давхацсан.../ зэрэгтэй холбоотой байна.

Энэ төрлийн хэргүүд нь ихэвчлэн хохирогчийн мэдүүлэг дээр түшиглэн мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг, нотлох баримтуудыг бэхжүүлдэг практиктай тул мөрдөн шалгах ажиллагааг хуульд заасан боломжит хугацаагаар хурдан хийх шаардлагатай. Ингэснээр хохирогчийн мэдүүлгийн дагуу хэргийн үйл баримтыг нотлох нотолгоонуудыг цаг алдалгүй бэхжүүлэх, хохирогчийн зөрчигдсэн эрхийг сэргээх, сэтгэл санаа болон бие махбодын хохирлыг нөхөн сэргээх ажиллагааг шийдвэрлүүлэх, шүүгдэгчээс хохирогчид нөлөөлөх нөлөөллийг таслан зогсоох зэрэгт ач холбогдолтой гэж шүүгч нар үзэж байлаа.

***Үр дүн 17. Шүүхийн практикт хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчид бодит мөнгөн дүнгийн хохирол нэхэмжлэхээс илүүтэй сэтгэл санааны, бие эрхтэнд учирсан хор уршгийн талаар хохирол нэхэмжлэх хандлагатай байдаг байна.***

Иргэний хуульд гагцхүү хуульд заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхөөр<sup>31</sup>, хохирогч "...гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах..."<sup>32</sup> эрхтэй гэж тус тус зааснаар хохирогчийн нэхэмжилж буй хохирлыг шүүх хянан шийдвэрлэх үүрэгтэй.

<sup>30</sup> Эрүүгийн хавтаст хэргийн материалаас


<sup>31</sup> Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсэг. 2002 он

<sup>32</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.9 дүгээр заалт. 2017 он.

Хохирогчийн хохирлоо гаргуулна гэсэн шаардлага бүхий иргэний нэхэмжлэлийг шүүх үндэслэл, хохирол хор уршгийн хэр хэмжээний нотлогдсон байдлыг харгалзан шийдвэрлэдэг<sup>33</sup> тул нотлох баримтгүй нэхэмжилж буй хохирлыг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар нэхэмжлэлээ гаргах эрхтэй болохыг нь зааж шийдвэрлэж байна. Судалгаанд оролцсон бүх шүүгч нар хохирогчийн сэтгэл санааны болон бие эрхтний хохирлоо нотлох баримтаа бүрдүүлэн иргэний шүүхээр жич шийдвэрлүүлэх эрхийг нь нээлттэй үлдээдэг гэсэн байна.

Шүүхээр хэрэг нь эцэслэн шийдвэрлэгдсэн 7 хүний 1 нь гаргасан нэхэмжлэл болох 1.8 сая төгрөгийн хохирлыг барагдуулсан бөгөөд бусад хохирогчдын тухайд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар гомдол гаргах эрхтэйг дурдаж хаасан байна.

*Зураг 28. Хохирогчдоос гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэх боломжгүй шалтгаан*



Хэдийгээр ингэж иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар жич нэхэмжлэх эрхийг заадаг талаар шүүгч нар хэлж байгаа боловч хохирлыг нэхэмжлэх:

- ✓ Хохирогчийн сэтгэл санааны гэмтлийг тодорхойлох мэргэжлийн эмч, мэргэжилтнийг шинжээчээр томилж, сэтгэл санааны хохирлыг эмчлүүлэх эмчилгээнд хамруулах,
- ✓ Сэтгэл санааны хохирлыг тооцох эрх зүйн орчинг яаралтай бий болгох,
- ✓ Хохирогчийн тухайн гэмт хэргийн хохирогч болсон хугацаа, нас, сэтгэл зүйн гэмтэл зэргийг нь харгалзсан сэтгэл зүйн хохирлыг тооцох аргачлал гаргах /гэмтлийн зэргийг тогтоох журам<sup>34</sup>-тай адил/ зэргээр нэхэмжлэлийн хэмжээгээ тогтоох боломж байгаа гэв.

Мөн гэм хорын нэхэмжлэлийг хангуулах зорилгоор иргэний хариуцагчаар хуулийн этгээд, иргэнийг татаж шүүх хуралдаанд оролцуулах, гэм буруугийн хуралдаанаар хохирогчид үйлчилгээ үзүүлсэн этгээд /өмгөөлөгчийн хөлс, байрлуулсны зардал, сэтгэл зүйчийн хөлс/ -ийн нэхэмжлэлийг гэм буруутай этгээдээс гаргуулж байгаа практик шүүхэд байдаг байна.

<sup>33</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. 2017 он.

<sup>34</sup> Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/216/422 дугаар тушаал

Судалгааны ярилцлагад оролцсон нэг шүүгч Засгийн газрын тогтоолын дагуу хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчид хохирлыг гаргуулах боломжтой гэсэн ба энэхүү журмыг судлахад, бидний судалгаа хийж буй гэмт хэргүүдээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах”, 12.3 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг” гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн хууль ёсны төлөөлөгч, хүний эрүүл мэндэд хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгохоор заасан<sup>35</sup> байлаа.

***Үр дүн 18. Эрүүгийн хуульд хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэрэгт оногдуулах хорих ялын интервал харьцангуй урт байна. Өөрөөр хэлбэл нэг гэмт хэрэгт ял шийтгэгдэж байгаа этгээдүүд хоорондоо харилцан адилгүй ял шийтгэгдэх боломжийг хуулиар бий болгосон байна.***

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ХХГХ болон түүнтэй төстэй хэрэгт оногдуулах ял, шийтгэлийн талаар дээр авч үзсэн. Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэргийн шүүгдэгчдэд бүгдэд нь хорих ял шийтгэл оногдуулжээ. Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн 2.2, 2.3 /хоёр ба түүнээс олон хүнийг, Монгол улсын хилээр нэвтрүүлж худалдаалсан/ дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйд 5 жилийн хорих ялыг, 13.1 дүгээр зүйлийн 2.1, 2.2/хүүхэд, жирэмсэн эмэгтэй мэдсээр байж, хоёр ба түүнээс олон хүнийг худалдаалсан/ дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн 4 хүнд 5-10 жилийн ялыг оногдуулжээ.

Эрүүгийн хуульд заасан хорих ял нь хүний эрх, эрх чөлөөг тодорхой хугацаагаар, тодорхой дэглэм бүхий газар хязгаарладгаараа ялын төрлийн хувьд хүнд ялд ордог боловч хүн худалдаалах гэмт хэргийг хүндрүүлэх хоёр шинжээр үйлдсэн этгээдэд Эрүүгийн хуульд заасан энгийн бүрэлдэхүүнтэй хэрэгт оногдуулах хорих ялын дээд хэмжээ 8 жилийн хорих ялаас бага хугацаагаар буюу 5 жилийн хугацаагаар хорих ялыг оногдуулж байгааг хүн худалдаалах гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, шүүгдэгчийн хувийн байдалд тохирсон гэж үзэхээргүй байна.

<sup>35</sup> Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 220 дугаар тогтоолоор батлагдсан Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмын 5.1-т зааснаар аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь өргөдлийг хүлээн авч, шаардлага хангасан эсэх, өргөдөл болон түүнд хавсаргасан баримт бичиг нь үнэн зөв эсэхийг тодруулж, холбогдох баримтын бүрдлийг 30 хоногт ханган, нөхөн төлбөрийг шийдвэрлүүлэх саналыг улирал тутам шаардлагатай тохиолдолд сар бүр хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.



*Шигтгээ 33.*

*Хэдийгээр шүүгчид Эрүүгийн хуульд заасан ялыг оногдуулж байгаа ч ХХГХ-ийн онцлог болох үргэлжилсэн хугацаанд, бүлэглэн үйлддэг шинж чанарт нь тохироогүй хэт бага ялыг хууль тогтоогч заасан. ХХГХ нь хохирогч олонтой, нийгмийн хор аюулын шинж чанараар нэг хүний эрх чөлөөний эсрэг үйлдэгддэг /хүчиндэх/ гэмт хэргээс хохирол, хор уршиг, хэр хэмжээний хувьд их байхад ял нь адилхан байгаа нь оновчтой биш. ХХГХ, түүнтэй төстэй гэмт хэргүүдийг хүндрүүлэх шинжгүйгээр үйлдсэн үед оногдуулахаар хуульд заасан ялын хэмжээ нь бага, оногдуулах ялын интервал /2-8 жил, 5-12 жил г.м/ нь маш их хол байгаа тул шүүхээс оногдуулсан ял шийтгэл дунджилсан харагдаж байгаа тал байна.*

*Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...*

Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэрэгт оногдуулах ялын хэмжээг Эрүүгийн хууль болон нэгдэн орсон Палермогийн протоколын зорилгыг хангахуйцаар энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанарт тохирсон хэмжээгээр Эрүүгийн хуульд заах зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна.

## ДҮГНЭЛТ

Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж, хүн худалдаалах явдалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд тодорхой ахицтай байна. мөн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг тодорхой хэмжээнд бүрдүүлж чадсан байна. Тухайлбал, УИХ-аас 2012 онд баталсан Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, хуулийг хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2017 онд баталсан Хүн худалдаалахтай тэмцэх Үндэсний хөтөлбөр, хууль тогтоомжийн өөрчлөлт шинэчлэлийн хүрээнд шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль, Донорын тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль зэрэг чухал ач холбогдолтой хууль тогтоомжуудыг батлан гаргаж тодорхой хугацаад хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай байна.

Төрийн байгууллагын мэдээллийн сан, мэдээллийн зөрүүтэй байдал нь судалгааны ажлын мэдээлэл цуглуулалтад багагүй саад учруулахын зэрэгцээ бидний хүссэн мэдээлэл гарах боломжтой ч гарч ирээгүй нь судалгааны үр дүнд бага зэрэг нөлөөлөв. Энэ нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон үндэсний хөтөлбөрт заасан энэ төрлийн гэмт хэргийн мэдээллийн сантай байх ажил учир дутагдалтай байгаагийн нэг илэрхийлэл гэж судалгааны баг үзсэн болно.

Судалгааны ажлын хүрээнд хүн худалдаалах болон түүнтэй төстэй хэргийг шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хянан шийдвэрлэж буй өнөөгийн нөхцөл байдлыг тодруулахад чиглэсэн бөгөөд судалгааны багаас дараах дүгнэлтийг хийж байна.

### **Эрх зүйн зохицуулалтын чиглэлээр:**

1. Монгол Улс 2008 онд Палермогийн протоколд нэгдэн орсон бөгөөд анх удаа энэхүү протоколын хэрэгжилтийн тайланг боловсруулж байгаа нь сайшаалтай байна.
2. Палермогийн протоколд нэгдэн орсноос хойш хүн худалдаалах явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах чиглэлээр нэлээдгүй эрх зүйн актуудыг батлан гаргасан бөгөөд үүний хамгийн тод илрэл нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль юм. Гэвч олон улсын байгууллагын санхүүжилтээр хийгдсэн судалгаанаас өөрөөр энэ хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг өнөө хэр нь хийгээгүй нь анхаарал татаж байна.
3. Хүн худалдаалах болон түүнтэй төстэй хэрэгт өртөж хохирсон төлбөрийн чадваргүй хохирогч хууль зүйн туслалцаа авах замаар хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах эрх зүйн боломж байхгүй байна. Түүнчлэн, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль

- зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар зохицуулсан ч өнөөдрийг хүртэл батлагдаагүй байна.
4. Гадаад улсад үйлдэгдсэн хүн худалдаалах болон түүнтэй төстэй хэрэгт нотлох баримт цуглуулах шаардлагатай байдаг учир эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг энэ төрлийн гэмт хэрэг ихээр үйлдэгдэж буй улсуудтай байгуулах зайлшгүй шаардлагатай байна.
  5. Палермогийн протоколтой нийцүүлж боловсруулсан Эрүүгийн хуульд заасан зарим зохицуулалт нь практикт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад төвөгтэй байдлыг үүсгэж байгаа нь үйлдэгсэд хөнгөн ялтай гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээх нөхцөлд хүргэж байна гэж бид үзэв. Үүнд:
    - 5.1 Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг” гэмт хэргийн 12.3.2, 12.3.4 дэх хэсэгт заасан хүндрүүлэх шинжид “энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж, ашиг олох зорилгоор” гэж заасан. Энэ нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах” гэмт хэрэгтэй өрсөлдүүлсэн хэм хэмжээ бий болсон байна.
    - 5.2 Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлд албадан хөдөлмөрлүүлэх явдлыг гэмт хэрэгт тооцохдоо мөн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан ХХГХ-ийн албадан хөдөлмөрлүүлж мөлжих үйлдлийн шинжийг давхардуулсан байна.
    - 5.3 Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт Хүүхдийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан нь нэг талаасаа хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн сайшаалтай зохицуулалт болсон. Гэвч 16.4 дүгээр зүйл Хүүхдээр гуйлга гуйлгах, 16.6 дугаар зүйл Хүүхэд худалдах, 16.8 дугаар зүйл Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, 16.9 дүгээр зүйл Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах, 16.10 дугаар зүйл Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийн шинжүүд нь ХХГХ-ийн шинжүүдтэй давхцаж байгааг анхаарах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн тайлбарт хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэн бол ямар аргаар хэрхэн үйлдсэн эсэхийг үл харгалзаж ХХГХ гэж үзэхээр тайлбарласан болно.
    - 5.4 Эрүүгийн хуулийн 15.3 дугаар зүйлд Хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах гэмт хэргийг заахдаа “хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдал, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж хүний цусыг, эсийг, эд, эрхтэнийг авсан” бол гэж заасан нь мөн хуулийн 13.1 дүгээр зүйл дэх ХХГХ-ийн агуулга нь “...хүний эд, эрхтэнийг авах...” үйлдэлтэй давхцаж байна.

### **Зөрчил шалгаж шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр:**

1. Шинэчлэн найруулсан Зөрчлийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн 6.18.4 дэх хэсэгт Биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, эсхүл бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон, 6.18.7 дахь хэсэгт Өөрийн эзэмшлийн байр, газарт биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд зуучилсан үйлдлийг тус тус зөрчил гэж үзэж, уг хуульд тусгасан байна. Гэвч цаг үеийн нөхцөл байдалд, практикт үйлдэгдэж буй биеэ үнэлэхийг зохион байгуулах зөрчлийн гаралт, нийгмийн хор аюулын шинж, байдлыг үндэслэн УИХ-аас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 6.18.7 дахь хэсгийг хүчингүй болгож мөн өдөр Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлд Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг хуульчилсан нь оновчтой зохицуулалт болжээ.
2. Цагдаагийн байгууллагад шалгагдсан зөрчлийн материалтай танилцах явцад Зөрчлийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн 6.18.4 дэх хэсэгт заасан зөрчилд ихэнхдээ биеэ үнэлж бусадтай бэлгийн харьцаанд орсон хүнд л хариуцлага тооцох явдал ажиглагдсан. Цаашид ч ийм байдал үргэлжлэх хандлагатай байгаа тул зөрчил шалгаж шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй эрх бүхий албан хаагч болон прокурорын хяналтыг сайжруулах шаардлагатай болох нь харагдаж байна. Гэхдээ түгээмэл үйлдэгддэг биеэ үнэлэхийг зохион байгуулж буй үйлдэл нь хүн худалдаалах гэмт хэргийн шинжтэй эсэхийг заавал тогтоох шаардлагатай гэж үзнэ.

### **Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно гэж заасан. Хэргийн төрлөөр дагнасан шүүх байгуулагдаагүй учир эрүүгийн хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдэд ХХГХ, түүний хохирогч нарын мэдүүлгийг ямар байдлаар үнэлэх, ялангуяа олон улсын практикт энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нарт явуулах шүүн таслах ажиллагаанд юуг анхаардаг, насанд хүрээгүй хохирогч нарыг хэрхэн хамгаалдаг зэрэг хохирогч хамгааллын үйл ажиллагааг шүүхээс хэрхэн явуулдаг, ял шийтгэлийг оногдуулахдаа юуг голчлон харгалзан үздэг зэрэг сургалтыг давтан, хэрэгцээг нь хангасан байдлаар зохион байгуулах замаар энэ төрлийн гэмт хэргийн онцлог ойлголт, мэдээлэл, мэдлэгийг дээшлүүлэх, ойлголтын зөрүүг арилгах явдал чухалд тооцогдож байна.
2. Палермогийн протокол, Эрүүгийн хуулийн зорилтыг хангахуйцаар хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн нийгмийн хор

- аюулын шинж чанарт тохирсон хэмжээгээр оногдуулах ялын хэмжээг тодорхойлох хэрэгтэй юм. Эрүүгийн хуульд оногдуулах хорих ялын ялын интервал хэт хол байгаа нь шүүхээс хууль хэрэглэхэд ойлгомжгүй, эргэлзээтэй байдлыг бий болгож байна.
3. ХХГХ-тэй өрсөлдөх хэмжээ бүхий зүйлүүдийг Эрүүгийн хуулийн тусгай ангид зааж, ялын хэмжээг хөнгөн заасан нь хууль хэрэглээний практикт хөнгөн гэмт хэргээр зүйлчлэх боломжийг бий болгож байгааг анхаарахаар байна.
  4. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын заалтыг ашиглах үзэгдэл шүүхийн практикт нэвтэрч эхэлсэн нь ажиглагдаж байна. Гэвч бусад баримт бичгүүд, тухайлбал эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг ашиглан хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн, бодитой тогтоох эрх зүйн боломж бүрдсэн байхад түүнийг ашиглан гадаад улсад нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа явуулах байдал хангалтгүй байна.
  5. Хүн худалдаалах түүнтэй төстэй гэмт хэргийн гаралт нь тоон статистикийн хувьд багассан хэдий ч энэ нь практикт буурсан гэж үзэх боломжгүй. Ингэж тоон үзүүлэлт буурч байгаа нь тус гэмт хэрэг багассанд бус, өрсөлдөх гэмт хэргүүдэд бүртгэгдэх, шийдвэрлэгдэж байгаатай холбоотой гэж судлаачдын баг дүгнэв. Үүний нэг жишээ нь, хүүхэд бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болох явдал нэмэгдэж байгаагаар илэрнэ.
  6. Хүн худалдаалах түүнтэй төстэй гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авмагц энэ төрлийн гэмт хэргийн талаар мэдлэгтэй, туршлагатай мөрдөгчид шилжүүлж, гэмт хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь тогтоох ажиллагааг явуулах нь хэргийн нөхцөл байдлыг тогтоох, хохирсон байж болзошгүй хүнд шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэх, нотлох баримтыг устах, гэмтэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм. Иймд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад энэ төрлийн гэмт хэргийн дагнасан мөрдөгчийг ажиллуулах шаардлага байна.
  7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нотлох баримтын олон төрлийг зааж өгсөн. Тухайлбал: мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мөрдөгчийн магадалгаа, гэрэл зураг, зураглал, дуу-дүрсний бичлэг, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл гэх мэт. Гэтэл хавтаст хэргийн материалтай танилцах явцад мэдүүлгэн нотлох баримтыг голчлон ашигласан байгаа нь харагдаж байв.
  8. Энэ төрлийн гэмт хэрэгт өртөж хохирсон насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг сайтар судлан зөв сонгож оролцуулах шаардлагатай байна. Ингээгүйгээс үйлдэгч нарын нөлөөнд автах,

нэгэнт хохирсон хохирогч нарыг өөрийг нь буруутгах, хайхрахгүй орхих зэрэг байдлууд байдаг байна. Түүнчлэн хууль ёсны төлөөлөгчийг хариуцлагажуулах шаардлага байна. Ялангуяа хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөгчийг энэ энэ төрлийн гэмт хэрэгт оролцох үеэс нь эхэлж, эрх үүргийг сайтар ойлгуулж, үүрэгжүүлэхгүй бол хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлдэггүй байдал анзаарагдлаа.

9. Хохирогч нарын сэтгэл зүйн хохирлыг тодорхойлох аргачлалыг яаралтай бий болгох шаардлагатай байна. Өнөө цагт мэргэшсэн сэтгэл зүйч нар манай улсад байх болсон ба энэхүү сэтгэл зүйчээс үйлчилгээ авч, хохирогчийн сэтгэл зүйн гэмтлийг тодорхойлох шаардлагатай. Учир нь, одоо мөрдөж буй Эрүүгийн хуульд хохирогчид учирсан хохирлыг дан ганц бие махбодод учирсан гэмтлийг зэргээр биш хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол гэж тодорхойлон зааж өгсөн. Иймд тодорхойлсон сэтгэл зүйн гэмтэл (учирсан хохирол)-ийн сэргээгдэх хугацаа, хохирогчийн нас зэргээс хамаарсан байдлаар нь биед нь хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол учирсан болохыг тогтоосон аргачлал байж болохоор байна. Ийм сэтгэл зүйн атлаас хохирогчийн биед учирсан хохирлыг тогтоох шинжээч нарыг ч ШШҮХ-д ажиллуулах бүрэн боломжтой гэж судлаачид бид дүгнэсэн. Үүнтэй уялдан сэтгэл зүйн хохирлыг арилгах сэтгэл зүйн эмчилгээний тарифаар хохирлыг гаргуулан хохирогчийн сэтгэл зүйн хохирлыг эмчлүүлэхээр байна.
10. Мөрдөгч, прокурор, шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ЭХХШТХ болон бусад хуулийг ягштал баримталж, хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх аргачлалыг нэвтрүүлэх шаардлага өндөр байна.

## ЗӨВЛӨМЖ

**Судалгааны ажлын үр дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.**

**Үр дүн 1.** Хэдийгээр Монгол Улс хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч хамгааллын чиглэлээр 12 олон улсын баримт бичигт нэгдэж, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаа ч энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгддэг, үйлдэгдэж болзошгүй улс орнуудтай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг байгуулах шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурал	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг /ХХГХ хамаарна/ ихээр үйлдэгдэж буй Норвеги, Швед, Арабын Нэгдсэн Эмират, Камбож, Япон, Малайз, Филиппин, АНУ зэрэг гадаадын улсуудтай Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг яаралтай байгуулах
Монгол Улсын Засгийн газар	Хууль зүй, дотоод хэргийн яам болон Гадаад харилцааны яамнаас өмнө нь байгуулсан эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний хэрэгжилтийг дүгнэх

**Үр дүн 2.** Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, хүн худалдаалахтай тэмцэх бие даасан хуулийг баталсны зэрэгцээ салбар хуулиар тодорхой асуудлуудыг зохицуулсан байна. Гэвч өнөөдрийг хүртэл бие даасан хуульд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдээгүй байна.

Монгол Улсын Засгийн газар	Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийж, цаашид хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр шат дараалсан арга хэмжээ авах;
----------------------------	---

**Үр дүн 3.** Биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон зөрчил буурах хандлагатай байгаа ч энэ цар тахлын нөхцөл байдлын улмаас тогтоосон хориглолт, хязгаарлалттай холбоотой байна.

**Үр дүн 4.** Биеэ үнэлэхийг зохион байгуулсан, зуучилсан гэж торгох шийтгэл хүлээсэн хүмүүсийн олонх нь эмэгтэйчүүд бөгөөд тэдний зарим нь энэ төрлийн зөрчлийг хэд хэдэн удаа үйлдэж байсан байна.

**Үр дүн 5.** Биеэ үнэлэх, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орох /биеэ үнэлэхийг зохион байгуулах/ зөрчлийг хялбаршуулсан журмаар шалгаж, шийдвэрлэх явдал түгээмэл байна.

Прокурорын байгууллага	Зөрчил шалгаж шийдвэрлэх тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, цагдаагийн байгууллагаас шалгасан энэ төрлийн зөрчлийн шинжид хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн шинж байгаа эсэхэд тавих хяналтаа сайжруулах
	Биеэ үнэлэх зөрчилд шийтгэл оногдуулахдаа бусдын биеийг үнэлж төлбөр төлсөн этгээдэд мөн шийтгэл оногдуулж байх талаар цагдаагийн байгууллагад шаардлага хүргүүлэх, хяналт тавих
Цагдаагийн байгууллага	Биеэ үнэлэх, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орох зөрчлийг илрүүлэн шалгахдаа хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтоох зорилгоор ЗШШТХ-д заасан бүхий л ажиллагааг хийж байх
	Энэ төрлийн зөрчлийг аль болох хялбаршуулсан журмаар шийдвэрлэхээс татгалзах
	Энэ төрлийн зөрчил нуугдмал байдалд шилжсэн байж болзошгүй тул түүнийг илрүүлэх талаар идэвх, санаачилгатай ажиллах
Баг, хорооны засаг дарга, нийгмийн ажилтнууд	Хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй энэ төрлийн зөрчил үйлдэгдэж болзошгүй газруудад тавих хяналтаа сайжруулж, зөрчилд холбогдож болзошгүй иргэдэд чиглэсэн урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээ зохион байгуулах
<b>Үр дүн 6.</b> Цагдаагийн байгууллагын бүтцэд ХХГХ болон Хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг мөрдөх бие даасан нэгж байгуулагдсан нь сайшаалтай байна.	
Монгол Улсын Засгийн газар	Цагдаагийн болон прокурорын байгууллагын бүтцэд бий болсон хүн худалдаалах болон хүүхдийн эсрэг үйлдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөх, хяналт тавих чиг үүрэг бүхий нэгжийг бэхжүүлэх, орон нутагт ажиллах орон тоо, бүтцийн асуудлыг шийдвэрлэх
Цагдаа, прокурорын байгууллага	Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэг болон хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг шалгах, хяналт тавих чиг үүрэг бүхий нэгжийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр тогтмол сургалтад хамруулж байх
	Эдгээр бүтцийн нэгжид ажиллаж буй алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар бодлогын шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх



<b>Үр дүн 7.</b> ХХГХ болон түүнтэй төстэй гэмт хэрэг, ялангуяа хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд оруулах замаар гэмт хэргийн хохирогч болгох явдал тогтвортойгоор өсөх хандлагатай байна.	
Цагдаагийн байгууллага	Хүүхдийн эсрэг үйлдэж буй хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн талаар хийсэн судалгааны үр дүнг үйл ажиллагаандаа ашиглаж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчлэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх
Хүүхдийн асуудал эрхэлсэн болон боловсролын асуудал эрхэлсэн байгууллага	Хүүхдийн эсрэг үйлдэж буй гэмт хэргийн талаарх ойлголт, мэдээллийг сурагчдад түгээх, тэднийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх
<b>Үр дүн 8.</b> Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж байгаа ч гомдол, мэдээллийг шалгах ажиллагааны төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх хуулийн боломж бүрдүүлэх шаардлагатай байна.	
Монгол Улсын Их Хурал	ЭХХШТХ-д нэмэлт оруулах замаар гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг шалгах ажиллагааны явцад мөн хуульд заасан мөрдөн шалгах нууц ажиллагаанаас бусад бүх ажиллагааг явуулах боломжтой байхаар хуульчлах /одоо 6 төрлийн ажиллагаагаар хязгаарлагдсан байгаа/
Цагдаа, прокурорын байгууллага	Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авсан бол аль болох хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзахгүй байх чиглэлд анхаарах. Шаардлагатай бүхий л ажиллагааг явуулж, үйл баримтыг хангалттай нотолсны дараа эрүүгийн хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэж байх
<b>Үр дүн 9.</b> ХХГХ, түүнтэй төстэй гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгаад, хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах ажиллагаанд Эрүүгийн хуульд ХХГХ-ийн хэлбэр бүрийг тусгайлан бие даасан гэмт хэрэг болгож зохицуулсан явдал сөргөөр нөлөөлөх хандлагатай байна.	

<p>Монгол Улсын Их Хурал</p>	<p>Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 12.3 дугаар зүйлд заасан Бэлгийн мөлжлөг 12.3.2, 12.3.3 дахь хэсэг, 13.13 дугаар зүйлд заасан Албадан хөдөлмөрлүүлэх, 15.3 дугаар зүйлд заасан Хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах, 16.4 дүгээр зүйлд заасан Хүүхдээр гуйлга гуйлгах, 16.6 дугаар зүйлд заасан Хүүхэд худалдах, 16.8 дугаар зүйлд заасан Хүүхэдэд садар самууныг сурталчлах, уруу татах, 16.9 дүгээр зүйлд заасан Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах, 16.10 дугаар зүйлд заасан Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг хүчингүй болгож энэ төрлийн гэмт хэргийг мөн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэнд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх ;</p> <p>Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, хэрэгжиж байгаатай уялдуулан Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд 1 дэх заалтад “цус, эс” ... гэж нэмэх</p>
<p>Монгол Улсын Дээд шүүх</p>	<p>Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүн худалдаалах болон түүнтэй төстэй хэргийг хэрхэн зүйлчлэх талаар тайлбар гаргах</p>
<p>Цагдаа, прокурорын байгууллага</p>	<p>Энэ төрлийн гэмт хэргийг аль болох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд зааснаар эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж, цугларсан нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэх /зүйлчлэл өөрчлөх гэх мэт/</p>
<p><b>Үр дүн 10.</b> Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэгт өртөж хохирсон иргэд нэн тэргүүнд хуулийн байгууллагад гэхээсээ илүүтэй төрийн бус байгууллагад хандаж туслалцаа дэмжлэг авах хандлагатай байна. Энэ нь хуулийн байгууллагад итгэх итгэлгүйн дээр тэдний харилцаа хандлагатай зарим талаараа хамааралтай байна.</p>	

Цагдаа, прокурорын байгууллага	Аливаа гэмт хэрэг, ялангуяа энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийн эмзэг байдал, ялгаатай байдлыг дээд зэргээр мэдэрч, мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогчийг буруутгахаас зайлсхийж, үйл ажиллагаандаа хохирогч төвтэй мөрдөн шалгах аргачлалыг нэвтрүүлэх
	ЭХХШтХ-д заасан зарчим, журмыг ягштал биелүүлж байх
	Хохирогчийн эрх, үүргийг тайлбарлахын зэрэгцээ ЭХХШтХ-д заасан хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах, гэмт этгээдийн зүгээс үзүүлж буй аюул заналаас хамгаалагдах боломжийн талаар тайлбарлаж өгч хэвших
	Хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах аргачлалд суурилан цагдаа, прокурорын байгууллагын алба хаагчдыг бэлтгэх, давтан сургах. Сургалтыг зохион байгуулахдаа цагдаагийн алба хаагчдад, прокуроруудад гэж ангилахаас илүүтэй хамтарсан байдлаар, ур чадварт суурилсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд явуулах
<b>Үр дүн 12.</b> Мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогчдоос хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах, өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах, мэдээллээр хангуулах, аюулгүй байдлаа хамгаалуулах боломж хязгаарлагдмал байна.	
Монгол Улсын Их Хурал	Хууль зүйн туслалцааг ялгаварлалгүй эдлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Хууль зүйн туслалцааны тухай хуулийг батлах.
Хууль зүй, дотоод хэргийн яам	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар зохицуулсан тул журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих
Шүүх, цагдаа, прокурорын байгууллага	ЭХХШтХ-д заасан хохирогчийн мэдээллээр хангуулах эрхийг баталгаатай эдлүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц болон бусад мэдээллийг хохирогчид өгч байх
Хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллага	Энэ төрлийн гэмт хэрэг хууль ёсны төлөөлөгчөөр оролцож буй хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэргэжилтнүүдэд чиглэсэн сургалтыг зохион байгуулж, чадвар эзэмшүүлэх

Хуульчдын болон өмгөөлөгчдийн өөрөө удирдах байгууллага	Хохирогчдод төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлдэг про-боно өмгөөлөгчдийн жагсаалтыг гаргах, хохирогчдод өмгөөллийн туслалцаа үзүүлэх чиглэлээр чадавхжуулах сургалтад хамруулах
<p><b>Үр дүн 13.</b> ХХГХ болон түүнтэй төстэй хэргийн хохирогчид өөрт учирсан хохирлоо тодорхойлох, түүнтэй холбоотой баримтыг хэрхэн гаргах, ямар байдлаар нөхөн төлүүлж болох талаар мэдлэг, ойлголтгүйн улмаас хохирлоо нэхэмжилж чадахгүй байна.</p> <p><b>Үр дүн 17.</b> Шүүхийн практикт хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчид бодит мөнгөн дүнгийн хохирол нэхэмжлэхээс илүүтэй сэтгэл санааны, бие эрхтэнд учирсан хор уршгийн талаар хохирол нэхэмжлэх хандлагатай байдаг байна.</p>	
Монгол Улсын Засгийн газар	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт хохирогчийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө гэж заасан хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс “Сэтгэл санааны хохирол тооцох” аргачлалыг яаралтай боловсруулж, практикт нэвтрүүлэх
Шүүхийн байгууллага	Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийн нэхэмжилсэн нэхэмжлэлийг аль болох хавтаст хэргийн хамт шийдвэрлэхэд анхаарах
Цагдаа, прокурорын байгууллага	Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг нотлох баримтыг өөрөөр нь гэхээсээ илүүтэй мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах замаар баримтжуулж, шүүхийн шийдвэрийн үндэслэл болгоход анхаарах
	Энэ төрлийн гэмт хэргийг шалгах, шийдвэрлэх ажиллагаанд сэтгэл зүйчийг аль болох байлцуулж байх /насанд хүрээгүй бол заавал оролцуулах/
<p><b>Үр дүн 11.</b> Энэ төрлийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах хугацаа харилцан адилгүй байна. Энэ нь тухайн хэргийн нөхцөл байдал, оролцогчдын тоо, нотлох ажиллагааны цар хүрээ болон бүртгэгдэх үедээ гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тогтоогдсон байсан эсэхтэй шууд хамааралтай байна.</p> <p><b>Үр дүн 14.</b> Шүүхээс хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийг шийдвэрлэж буй тоон үзүүлэлт жил бүр өсөж байгаа нь сайн үзүүлэлт юм. Гэвч энэ нь нийт бүртгэгдсэн, шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн тоотой харьцуулахад цөөн байна.</p> <p><b>Үр дүн 16.</b> Шүүхээс ХХГХ болон түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх хугацаа харилцан адилгүй байна.</p>	

Монгол Улсын Засгийн газар	Хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийг бүртгэх, хэргийн хөдөлгөөнийг хянах, хохирогчид үзүүлж буй үйлчилгээний талаарх бүх мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн санг бий болгох
Цагдаа, прокурорын байгууллагад	Мөрдөн шалгах ажиллагаа хэрэгжүүлж буй мөрдөгч, хяналт тавьж буй прокурорыг аль болох солихгүйгээр мөрдөн шалгах ажиллагааг явуулах. Шаардлагатай тохиолдолд ЭХХШТХ-д заасан мөрдөгчдийн ажлын хэсэг байгуулах асуудлыг хэргийн нөхцөл байдал, оролцогчдын тооноос хамаарч зохион байгуулах
	Мөрдөн шалгах ажиллагааг аль болох хуулийн богино боломжит хугацаанд явуулах, ингэхдээ хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтооход анхаарах
	Судалгааны үр дүнгээс харвал 2017-2021 онд цагдаагийн байгууллагад хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэг нийт 241 бүртгэгдэж, 3 хэрэг хэрэгсэхгүй болж, 137 хэргийн хэрэг бүртгэлтийг хаасан нь нийт гэмт хэргийн 58% нь мөрдөн байцаалтын болон прокурорын хяналтын шатанд дуусгавар болж байгааг анхаарч, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэрэгсэхгүй болгосон хэргийн үндэслэл бүрэн нотлогдсон эсэх, шаардлагатай мөрдөн шалгах ажиллагаа явагдсан эсэх талаар судалгаа хийх
Шүүхийн байгууллага	Цагдаагийн байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулж, прокурор яллагдагчаар татаж шүүхэд шилжүүлсэн 3 хэрэг тутмын нэг нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн байгаад анхаарч, цаашид хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, шүүхэд хуулийн хамгийн боломжит богино хугацаа зарцуулж, хэргийг шийдвэрлэж байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах
<b>Үр дүн 15.</b> Шүүхийн байгууллагад ХХГХ, түүнтэй төстэй хэргийг дагнан шийдвэрлэх шүүгч байхгүй ч ийм төрлийн дагнасан шүүгч ажиллах хэрэгцээ шаардлага одоогоор байхгүй гэж шүүгч нар үзэж байна.	
Шүүхийн байгууллагад	Хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх аргачлалд суурилан шүүх эрх мэдлийн байгууллагын алба хаагчдыг бэлтгэх, давтан сургах ур чадварт суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх

<p><b>Үр дүн 18.</b> Эрүүгийн хуульд хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэрэгт оногдуулах хорих ялын интервал харьцангуй урт байна. Өөрөөр хэлбэл нэг гэмт хэрэгт ял шийтгэгдэж байгаа этгээдүүд хоорондоо харилцан адилгүй ял шийтгэгдэх боломжийг хуулиар бий болгосон байна.</p>	
Монгол Улсын Их Хурал	Эрүүгийн хуульд энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын интервалыг Палермогийн протоколын зорилгыг хангахуйцаар тогтоосон байдлаар нийцүүлэн өөрчлөх
Шүүхийн байгууллага	Хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэрэгт ял оногдуулахдаа харилцан адилгүй ял шийтгэл оногдуулахгүй байхад анхаарч, нэгдсэн ойлголттой болох чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах, нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 1992, №1
2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2019, №42
3. Донорын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2018, №6
4. Зар сурталчилгааны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2002 №23
5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2017, №24
6. Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2017, №24,
7. Иргэний хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2002, №7
8. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ., 2021, №5
9. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2013, №30
10. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2012, №7
11. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2015, №7
12. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2017, №23
13. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 220 дугаар тогтоол
14. Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/216/422 дугаар тушаал
15. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2020 оны А/63 дугаар тушаал
16. Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны А/32 дугаар тушаал
17. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Иргэдэд туслах хүний эрхийн төв ТББ, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа”, УБ., 2017
18. <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2019-trafficking-in-persons-report-mn/>
19. See other key International Conventions related to trafficking <https://www.unodc.org/e4j/en/tip-and-som/module-6/key-issues/international-legal-framework.html>
20. United Nations Convention against Transnational Organized Crime and the Protocols Thereto <https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html>
21. <http://mfa.gov.mn/#>







